

ТАМХИН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ  
ХУУЛЬ БУС ХУДАЛДААГ  
УСТГАХ ТУХАЙ

# ПРОТОКОЛ



**FCTC**

WHO FRAMEWORK CONVENTION  
ON TOBACCO CONTROL

**ДЭМБ-ЫН ТАМХИНЫ ХЯНАЛТЫН СУУРЬ КОНВЕНЦ**

**ТАМХИН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ  
ХУУЛЬ БУС ХУДАЛДААГ  
УСТГАХ ТУХАЙ ПРОТОКОЛ**

Эх хувилбартай дараах хаягаар танилцана уу:

<https://fctc.who.int/publications/i/item/9789241505246>

# ГАРЧИГ

<b>ТАМХИН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХУУЛЬ БУС ХУДАЛДААГ УСТГАХ ТУХАЙ ПРОТОКОЛ</b>	<b>5</b>
УДИРТГАЛ	5
<b>I ХЭСЭГ: ТАНИЛЦУУЛГА</b>	<b>7</b>
1 ДҮГЭЭР ЗҮЙЛ. НЭР ТОМЪЁО	7
2 ДУГААР ЗҮЙЛ. ПРОТОКОЛ, БУСАД ГЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЭР, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ХАРИЛЦАА	8
3 ДУГААР ЗҮЙЛ. ЗОРИЛГО	8
<b>II ХЭСЭГ: ЕРӨНХИЙ ҮҮРЭГ</b>	<b>9</b>
4 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ЕРӨНХИЙ ҮҮРЭГ	9
5 ДУГААР ЗҮЙЛ. ХУВИЙН МЭДЭЭГ ХАМГААЛАХ	9
<b>III ХЭСЭГ: ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ СҮЛЖЭЭНИЙ ХЯНАЛТ</b>	<b>10</b>
6 ДУГААР ЗҮЙЛ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗӨВШӨӨРӨЛ БУЮУ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО	10
7 ДУГААР ЗҮЙЛ. ХӨНДЛӨНГИЙН СУДАЛГАА	12
8 ДУГААР ЗҮЙЛ. МӨРДӨН ШАЛГАХ БА ХЯНАН ТОГТООХ	13
9 ДҮГЭЭР ЗҮЙЛ. БҮРТГЭЛ, ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ХӨТЛӨЛТ	15
10 ДУГААР ЗҮЙЛ. АЮУЛГҮЙ БАЙДАЛ БОЛОН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	16
11 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ИНТЕРНЭТ, ЦАХИЛГААН ХОЛБОО ЭСХҮЛ ШИНЭЭР ХӨГЖИЖ БУЙ БУСАД ТЕХНОЛОГИОР ДАМЖУУЛАН ХИЙХ ХУДАЛДАА	17
12 ДУГААР ЗҮЙЛ. ЧӨЛӨӨТ БҮС БА ОЛОН УЛСЫН ДАМЖИН ӨНГӨРҮҮЛЭЛТ	17
13 ДУГААР ЗҮЙЛ. ТАТВАРГҮЙ ХУДАЛДАА	17
<b>IV ХЭСЭГ: ГЭМТ ХЭРЭГ</b>	<b>18</b>
14 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ХУУЛЬ БУС ҮЙЛДЭЛ, ТЭР ДУНДАА ЭРҮҮГИЙН ГЭМТ ХЭРЭГ	18
15 ДУГААР ЗҮЙЛ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХАРИУЦЛАГА	19
16 ДУГААР ЗҮЙЛ. ХАРИУЦЛАГА БА ШҮҮХ АЖИЛЛАГАА	20
17 ДУГААР ЗҮЙЛ. ХУРААН АВАХ ТӨЛБӨР	20
18 ДУГААР ЗҮЙЛ. УСТГАХ	20
19 ДҮГЭЭР ЗҮЙЛ. МӨРДӨН БАЙЦААХ ТУСГАЙ АРГА	20
<b>V ХЭСЭГ: ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА</b>	<b>22</b>
20 ДУГААР ЗҮЙЛ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ	22
21 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ПРОТОКОЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ	22
22 ДУГААР ЗҮЙЛ. МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ: МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ, ХАМГААЛАЛ	23

23 ДУГААР ЗҮЙЛ. ДЭМЖЛЭГ БА ХАМТЫН АЖИЛЛАГАА: ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН АСУУДЛААРХ СУРГАЛТ, ТЕХНИКИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХАМТЫН АЖИЛЛАГАА	23
24 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ДЭМЖЛЭГ БА ХАМТЫН АЖИЛЛАГАА: ЗЗГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН БАЙЦААХ, ШҮҮХЭД ХЯНАХ	23
25 ДУГААР ЗҮЙЛ. БҮРЭН ЭРХТ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ	24
26 ДУГААР ЗҮЙЛ. ХЭРГИЙН ХАРЬЯАЛАЛ	24
27 ДУГААР ЗҮЙЛ. ХУУЛЬ САХИН БИЕЛҮҮЛЭХ ТАЛААРХ ХАМТЫН АЖИЛЛАГАА	25
28 ДУГААР ЗҮЙЛ. ЗАХИРГААНЫ ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА	26
29 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА	26
30 ДУГААР ЗҮЙЛ. СЭЖИГТЭН ЭТГЭЭДИЙГ ШИЛЖҮҮЛЭХ	30
31 ДҮГЭЭР ЗҮЙЛ. СЭЖИГТЭН ЭТГЭЭДИЙГ ШИЛЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	31
<b>VI ХЭСЭГ: ТАЙЛАГНАХ</b>	<b>32</b>
32 ДУГААР ЗҮЙЛ. МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ, ТАЙЛАГНАХ	32
<b>VII ХЭСЭГ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА САНХҮҮГИЙН НӨӨЦ</b>	<b>33</b>
33 ДУГААР ЗҮЙЛ. ТАЛУУДЫН УУЛЗАЛТ	33
34 ДҮГЭЭР ЗҮЙЛ. НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ГАЗАР	33
35 ДУГААР ЗҮЙЛ. ТАЛУУДЫН УУЛЗАЛТ БОЛОН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН ХАРИЛЦАА	34
36 ДУГААР ЗҮЙЛ. САНХҮҮГИЙН НӨӨЦ	34
<b>VIII ХЭСЭГ: МАРГААН ШИЙДВЭРЛЭХ</b>	<b>36</b>
37 ДУГААР ЗҮЙЛ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ	36
<b>IX ХЭСЭГ: ПРОТОКОЛЫН БОЛОВСРУУЛАЛТ</b>	<b>37</b>
38 ДУГААР ЗҮЙЛ. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ	37
39 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ЭНЭХҮҮ ПРОТОКОЛЫН ХАВСРАЛТЫГ БАТЛАХ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ	37
<b>X ХЭСЭГ: БУСАД</b>	<b>38</b>
40 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ТАЙЛБАР	38
41 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ЦУЦЛАХ	38
42 ДУГААР ЗҮЙЛ. САНАЛ ӨГӨХ ЭРХ	38
43 ДУГААР ЗҮЙЛ. ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ	38
44 ДҮГЭЭР ЗҮЙЛ. СОЁРХОН БАТЛАХ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, БАТЛАХ БОЛОН НЭГДЭН ОРОХ	38
45 ДУГААР ЗҮЙЛ. ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ	39
46 ДУГААР ЗҮЙЛ. ЭХ ХАДГАЛАГЧ	39
47 ДУГААР ЗҮЙЛ. ЖИНХЭНЭ БИЧВЭР	39

# ТАМХИН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХУУЛЬ БУС ХУДАЛДААГ УСТГАХ ТУХАЙ ПРОТОКОЛ

## УДИРТГАЛ

*Протоколд оролцогч талууд*

Дэлхийн Эрүүл Мэндийн 56 дугаар Чуулганаар 2003 оны 5 дугаар сарын 21-ний өдөр батлагдаж, 2005 оны 2 дугаар сарын 27-ны өдөр хүчин төгөлдөр болсон ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцыг *анхаарч*;

Тамхины Хяналтын Суурь Конвенц нь НҮБ-ын хамгийн хурдан дэмжигдэж батлагдсан гэрээ бөгөөд ДЭМБ-ын зорилтууддаа хүрэх үндсэн арга хэрэгсэл болохыг *хүлээн зөвшөөрч*;

Эрүүл мэндийн хүрч болох дээд түвшин нь арьс өнгө, шашин, улс төрийн итгэл үнэмшил, эдийн засаг, нийгмийн байдлыг үл харгалзан хүн бүрийн эдлэх үндсэн эрх болохыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Үндсэн хуулийн Удиртгалд тэмдэглэснийг *дурдаж*;

Түүнчлэн тэдний нийгмийн эрүүл мэндийг хамгаалах эрхэд тэргүүлэх ач холбогдол өгөхөөр *шийдэж*;

Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааны хамрах цар хүрээ, хэмжээ нь тамхины тархалтад нөлөөлж, энэ нь нийгмийн эрүүл мэндэд ноцтой үр дагавар учруулсан дэлхий нийтийн асуудал болж, дотоодын болон олон улсын түвшинд үр дүнтэй, зохих ёсны цогц арга хэмжээ авахыг шаардаж буйд *сэтгэл гүнээ зовниж*;

Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаа нь тамхинд тавих үнийн болон татварын хяналтын арга хэмжээг унагаж, тэр хэмжээгээр тамхин бүтээгдэхүүн худалдан авах чадвар, хүртээмжийг нэмэгдүүлж байгааг *нэмж хүлээн зөвшөөрч*;

Хууль бусаар худалдаалагдаж буй тамхин бүтээгдэхүүнийг худалдан авах чадвар, түүний хүртээмж нэмэгдэж байгаа нь нийгмийн, нэн ялангуяа залуус, ядуу болон бусад эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэнд, сайн сайхан байдалд таагүй нөлөө үзүүлж байгаад *зовниж*;

Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаа нь хөгжиж буй орнууд, эдийн засгийн шилжилтийн орнуудын нийгэм, эдийн засагт онцгой их сөрөг нөлөө үзүүлж буй талаар *онцгойлон зовниж*;

Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааны бүх хэлбэрийг устгах үндэсний, бүс нутгийн болон олон улсын зохих арга арга хэмжээг төлөвлөх болон хэрэгжүүлэх шинжлэх ухаан, техникийн болон байгууллагын чадавхийг хөгжүүлэх хэрэгцээ байгааг *ойлгож*;

Мэдээллийн хүртээмж болон холбогдох технологи Талуудын чадварыг бэхжүүлэхэд, ялангуяа хөгжиж буй орнууд, эдийн засгийн шилжилтийн орнуудад тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааны бүх хэлбэрийг устгахад онцгой ач холбогдолтой болохыг *хүлээн зөвшөөрч*;

Худалдааны чөлөөт бүсүүд хууль ёсны худалдааг дэмжихээр байгуулагдсан ч, тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааны даяаршлыг дэмжихэд буюу нууцаар хил нэвтрүүлсэн бүтээгдэхүүний хууль бус дамжин өнгөрүүлэлт болон тамхин бүтээгдэхүүний хууль бус үйлдвэрлэлд аль алинд ашиглагдаж байгааг *мөн хүлээн зөвшөөрч*;

Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаа нь Талуудын эдийн засаг, тогтвортой байдал болон аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буйг *мөн хүлээн зөвшөөрч*;

Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаа нь засгийн газрын зорилтуудыг хэрэгжүүлэхэд саад учруулах үндэстэн дамнасан эрүүгийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд хэрэглэгдэх асар их хэмжээний санхүүгийн ашиг орлого бий болгож байгааг *мөн ойлгож*;

Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаа нь эрүүл мэндийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд саад учруулж, эрүүл мэндийн тогтолцоонд нэмэлт ачаалал үүсгэж, Талуудын эдийн засгийг алдагдалд оруулж байгааг *цохон тэмдэглэж*;

Талууд тамхины хяналтын талаар нийгмийн эрүүл мэндийн бодлогоо тодорхойлон хэрэгжүүлэхдээ үндэсний хууль тогтоомжийн хүрээнд эдгээр бодлогыг тамхи үйлдвэрлэгчдийн худалдааны болон бусад ашиг сонирхлоос хамгаалах үүрэг хүлээх талаар Талууд зөвшилцсөн ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын 5.3 дугаар зүйлийг *санаж*;

Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах стратегийг үгүй хийх гэсэн тамхины үйлдвэрлэлийн аливаа хүчин чармайлтаас сэрэмжлүүлэх, тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаатай тэмцэх стратегид сөрөг үр нөлөө үзүүлж байгаа тамхины үйлдвэрлэлийн үйл ажиллагааг мэдээлэх хэрэгцээ байгааг *дурдан*;

Талуудыг олон улсын жуулчдын тамхин бүтээгдэхүүний татваргүй худалдаа болон/эсхүл импортыг хориглох эсхүл зохих ёсоор хязгаарлахыг хөхиүлэн дэмжсэн ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын 6.2 дугаар зүйлийг *санаж*;

Олон улсаар дамжин өнгөрч буй тамхи болон тамхин бүтээгдэхүүн нь хууль бус худалдааны суваг руу дамжих боломж байгааг *нэмж хүлээн зөвшөөрч*;

Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаатай тэмцэх, урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ нь хууль бус худалдааны бүхий л төлөвт, түүний дотор тамхи болон тамхин бүтээгдэхүүн, түүнийг үйлдвэрлэхэд хэрэглэгддэг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хууль бус худалдаанд олон улсын цогц чиг хандлага, ойрын хамтын ажиллагааг шаардаж байгааг *анхааралдаа авч*;

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц, Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус тээвэрлэлтийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц зэрэг олон улсын бусад хэлэлцээрийн ач холбогдол, мөн эдгээр хэлэлцээрт нэгдсэн Талууд хэлэлцээрийн холбогдох заалтуудыг тамхи, тамхин бүтээгдэхүүн, түүнийг үйлдвэрлэхэд хэрэглэгддэг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хууль бус худалдаатай тэмцэхэд ашиглах, хэлэлцээрт нэгдээгүй Талууд нэгдэхийн чухлыг *онцгойлон тэмдэглэж*;

ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын Нарийн бичгийн даргын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах бодис болон гэмт хэрэгтэй тэмцэх газар, Дэлхийн гаалийн байгууллага болон бусад талын хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх хэрэгцээ зүй ёсоор тавигдаж байгааг *хүлээн зөвшөөрч*;

Талууд тамхин бүтээгдэхүүнийг нууцаар хил нэвтрүүлэх, хууль бусаар үйлдвэрлэх зэрэг хууль бус худалдааны бүх хэлбэрийг устгах нь тамхины хяналтын хамгийн чухал бүрэлдэхүүн хэмээн ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын 15 дугаар зүйлд хүлээн зөвшөөрснийг *дахин дурдаж*;

Энэхүү протокол нь оюуны өмчийн эрхийн асуудлыг зохицуулахаар зориогүй гэдгийг харгалзан; мөн ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын зэрэгцээ цогц протоколтой байх нь тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаа болон түүний онц хүнд хор уршигт эсэргүүцэл үзүүлэх хүчирхэг, үр дүнтэй арга гэдэгт *итгэж*,

Дараах зүйлийг хэлэлцэн тохиров:

## I ХЭСЭГ: ТАНИЛЦУУЛГА

### 1 ДҮГЭЭР ЗҮЙЛ

#### НЭР ТОМЪЁО

1. «Брокерийн үйл ажиллагаа» гэж төлбөр буюу ашгийн хувь авах нөхцөлтэйгөөр бусад этгээдийг төлөөлж гэрээ хэлэлцээ, худалдан авах буюу борлуулах үйл ажиллагаанд оролцохыг хэлнэ.
2. «Янжуур тамхи» гэж тамхины навчийг боловсруулж зориулалтын цаасанд ороож бэлдсэн бүтээгдэхүүн. Үүнд «бидис», «анг хун» зэрэг зарим бүс нутагт дэлгэрсэн цаас буюу навчинд ороож хэрэглэдэг тамхин бүтээгдэхүүн хамаарахгүй. 8 дугаар зүйлд нийцүүлэн «янжуур тамхи» гэдэгт хувийн хэрэглээндээ зориулж зориулалтын төхөөрөмжийн тусламжтай тамхины цаасанд ороож бэлдсэн бүтээгдэхүүнийг хамруулсан болно.
3. «Хураах» гэж шүүх буюу бусад эрх бүхий байгууллагын шийдвэрээр эд хөрөнгийг бүрмөсөн хураан авахыг хэлнэ.
4. «Хяналтан дор хүргүүлэх» гэж гэмт хэргийг мөрдөн шалгах, түүнийг үйлдэхэд оролцсон этгээдийг тогтоох зорилгоор хууль бус, эсхүл сэжигтэй ачаа барааг нэг буюу хэд хэдэн орны нутаг дэвсгэрээс гаргах, эсхүл түүгээр дамжуулах, эсхүл нутаг дэвсгэрт нь нэвтрүүлэхийг тэдгээр улсын эрх бүхий байгууллагын мэдэл, хяналтан дор зөвшөөрсөн байхыг хэлнэ.
5. «Чөлөөт бүс» гэж Талуудын нутаг дэвсгэрт хамаарах боловч бараа бүтээгдэхүүнд импортын төлбөр татвар ногдуулдаггүй гаалийн хилд ордоггүй нутаг дэвсгэрийг хэлнэ.
6. «Хууль бус худалдаа» гэж бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, тээвэрлэх, хүлээн авах, эзэмших, түгээх, худалдаалахад хуулиар хориглосон үйлдэл хийх, тийм үйлдлийг дэмжих зорилго бүхий аливаа үйл ажиллагааг хэлнэ.
7. «Тусгай зөвшөөрөл» гэж эрх бүхий байгууллагад гаргасан өргөдөл болон бусад баримт бичгийн дагуу эрх бүхий байгууллагаас олгож буй зөвшөөрлийг хэлнэ.
8. (а) «Үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмж» гэж зөвхөн тамхин бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зорилгоор бүтээсэн буюу өөрчилсөн бөгөөд үйлдвэрлэлийн үйл явцын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон тоног төхөөрөмжийг хэлнэ.  
(б) «Түүний аливаа эд анги» гэж тамхин бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн өвөрмөц эд ангийг хэлнэ.<sup>1</sup>
9. «Талууд» гэж тухайн нөхцөлд өөрөөр заагаагүй бол энэ Протоколын Талуудыг хэлнэ.
10. «Хувийн мэдээ» гэж тухайн хувь хүнийг тодорхойлж болохуйц мэдээллийг хэлнэ.

<sup>1</sup> Талууд энэхүү зорилгоор Дэлхийн гаалийн байгууллагын Бараа бүтээгдэхүүнийг кодлох нэгдсэн системийг ашиглаж болно.

11. «Бүсийн эдийн засгийн интеграцийн байгууллага» гэж Талууд тодорхой асуудлаар шийдвэр гаргах эрх мэдлээ шилжүүлдэг, хэд хэдэн тусгаар улсаас бүрдсэн байгууллагыг хэлнэ.<sup>2</sup>
12. «Ханган нийлүүлэлтийн сүлжээ» гэж тамхин бүтээгдэхүүн, түүний үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, импорт, экспортыг хамрах ойлголт бөгөөд Талуудын шийдвэрлэснээр дараах үйл ажиллагаанд хамруулж болно. Үүнд:
  - (а) тамхин бүтээгдэхүүний жижиглэн худалдаа;
  - (б) уламжлалт бага хэмжээний тариалалтаас бусад тамхины тариалалт;
  - (в) худалдааны зорилгоор их хэмжээний тамхин бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийг тээвэрлэх; болон
  - (г) тамхи, тамхин бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн бөөний худалдаа, брокерийн үйл ажиллагаа, хадгалалт, түгээлт.
13. «Тамхин бүтээгдэхүүн» гэж татах, үнэрлэх, зажлах зорилгоор тамхины навчийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түүхий эд болгон үйлдвэрлэсэн хэрэглээний бүтээгдэхүүнийг хэлнэ.
14. «Мөрдөн шалгах ба хянан тогтоох» гэж эд юмсын ханган нийлүүлэлтийн сувгаар дамжих хөдөлгөөн, байршлыг эрх бүхий байгууллага, эсвэл түүнийг төлөөлж буй этгээдийн зүгээс системтэй хянах, нэхэн тогтоохыг хэлнэ.

## **2 ДУГААР ЗҮЙЛ**

### **ПРОТОКОЛ, БУСАД ГЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЭР, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ХАРИЛЦАА**

1. ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын протоколд хамаатай зүйл, заалтууд нь энэхүү Протоколд нэгэн адил хамаарна.
2. Протоколд нэгдэн орсон Талууд ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын 2-р зүйлд дурдсан Гэрээ байгуулсан тохиолдолд Конвенцын Нарийн бичгийн даргын газраар уламжлан Талуудын хуралд уг гэрээний талаар танилцуулна.
3. Энэхүү Протокол нь аливаа Талын тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах талаар амжилтад хүрэхэд илүү дөхөмтэй хэмээн үзэж соёрхон баталсан бусад олон улсын конвенц, гэрээ, олон улсын хэлэлцээрээр хүлээсэн эрх, үүрэгт нөлөөлөхгүй.
4. Энэхүү Протокол нь олон улсын хууль, түүн дотроо Үндэстэн Дамнасан Зохион Байгуулалттай Гэмт Хэргийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын дагуу Талуудын хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагад нөлөөлөхгүй.

## **3 ДУГААР ЗҮЙЛ**

### **ЗОРИЛГО**

Энэхүү Протоколын зорилго нь ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын 15 дугаар зүйлд заасан нөхцөлийн дагуу тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааны бүх хэлбэрийг устгахад оршино.

<sup>2</sup> Үндэсний буюу дотоодын хүсэл зориг бүсийн эдийн засгийн интеграцийн байгууллагад үүний нэгэн адил хамаарна.



## II ХЭСЭГ: ЕРӨНХИЙ ҮҮРЭГ

### 4 ДҮГЭЭР ЗҮЙЛ

#### ЕРӨНХИЙ ҮҮРЭГ

1. Талууд нь ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын 5 дугаар зүйлийн заалтууд дээр нэмж дараах үүрэг хүлээнэ:
  - (а) энэхүү Протоколын зүйл, заалтад заасан бараа бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэх сүлжээг хянах, зохицуулах үр дүнтэй арга хэмжээ хэрэгжүүлж тэдгээр бараа бүтээгдэхүүний хууль бус худалдаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах, прокурорын хяналт хийх, энэхүү зорилгоор нэг нэгэнтэйгээ хамтран ажиллах;
  - (б) энэхүү Протоколд заасан бараа бүтээгдэхүүний хууль бус худалдааны бүх хэлбэрийг устгах, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн шалгах, прокурорын хяналт хийх чиг үүрэг бүхий гааль, цагдаа зэрэг эрх бүхий байгууллага, үйлчилгээний үр нөлөөг дээшлүүлэх талаар дотоодын хууль, тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээ авах;
  - (в) энэхүү Протоколын зорилтод хүрэхийн тулд техникийн туслалцаа, санхүүгийн дэмжлэг олж авах, чадавхийг бэхжүүлэх болон олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх, энэхүү Протоколын хүрээнд мэдээлэл харилцан солилцох эрх бүхий байгууллагуудтай мэдээллийг найдвартай харилцан солилцох, тэдэнд мэдээллийг хүртээмжтэй байлгах;
  - (г) энэхүү Протоколын 14 дүгээр зүйлд заасан хууль бус үйл ажиллагаа, түүн дотроо эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх хууль сахиулах ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд дотоодын хууль тогтоомж, захиргааны тогтолцоонд нийцүүлэн нэг нэгэнтэйгээ хамтран ажиллах;
  - (д) энэхүү Протоколын үр дүнтэй хэрэгжилтийг дэмжих үүднээс Протоколд заасан мэдээллийг найдвартай<sup>3</sup> солилцоход бүс нутгийн болон олон улсын засгийн газар хоорондын байгууллагуудтай шаардлагатай хэмжээнд харилцах, хамтран ажиллах, болон
  - (е) өөрийн нөөц, бололцооны хүрээнд энэхүү Протоколыг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс хоёр талт, олон талт санхүүгийн механизмаар уламжлан санхүүгийн эх үүсвэр бий болгох талаар хамтран ажиллах.
2. Энэхүү Протоколоор хүлээсэн үүргээ биелүүлэхдээ Талууд тамхи үйлдвэрлэгчтэй үүсч болох аливаа харилцааг аль болох ил тод, тунгалаг байлгана.

### 5 ДУГААР ЗҮЙЛ

#### ХУВИЙН МЭДЭЭГ ХАМГААЛАХ

Талууд энэхүү Протоколыг хэрэгжүүлэхдээ хувийг мэдээг хамгаалах тухай олон улсын стандартыг харгалзаж, үндэсний хууль тогтоомжийн хүрээнд хувь хүний мэдээг яс үндэс, оршин суух газрыг үл харгалзан хамгаалах үүрэгтэй.

<sup>3</sup> Хоёр талын хоорондын мэдээллийн найдвартай солилцоо нь аливаа хандлагаас хамгаалагдсан байна. Өөрөөр хэлбэл хоёр талын хооронд солилцож буй мэдээллийг гуравдагч этгээд уншиж, өөрчилж чадахгүй.

### III ХЭСЭГ: ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ СҮЛЖЭЭНИЙ ХЯНАЛТ

#### 6 ДУГААР ЗҮЙЛ

##### ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗӨВШӨӨРӨЛ БУЮУ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

1. Тал бүр ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын зорилтуудыг хэрэгжүүлэх, тамхи, тамхин бүтээгдэхүүн, тэдгээрийн үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн хууль бус худалдааг устгахтай холбоотойгоор үндэсний хууль тогтоомжийн хүрээнд эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл эсхүл түүнтэй адилтгах зөвшөөрөл (цаашид «тусгай зөвшөөрөл» гэх) аваагүй буюу хяналтын тогтолцоо хэрэгжүүлээгүй хувь хүн, хуулийн этгээдэд дараах үйл ажиллагааг эрхлэн явуулахыг хориглоно. Үүнд:
  - (а) тамхин бүтээгдэхүүн болон түүний үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх;
  - (б) тамхин бүтээгдэхүүн болон түүний үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийг импортлох буюу экспортлох.
2. Тал бүр үндэсний хууль тогтоомжоор хориглоогүй нөхцөлд аливаа хуулийн этгээд буюу хувь хүний эрхлэх дараах үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй болгохыг эрмэлзэнэ. Үүнд:
  - (а) тамхин бүтээгдэхүүний жижиглэн худалдаа;
  - (б) уламжлалт бага хэмжээний тариалалтаас бусад тамхины тариалалт;
  - (в) худалдааны зорилгоор их хэмжээний тамхин бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийг тээвэрлэх; болон
  - (г) тамхи, тамхин бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн бөөний худалдаа, брокерийн үйл ажиллагаа, хадгалалт, түгээлт.
3. Тусгай зөвшөөрлийн үр дүнтэй тогтолцоо бүрдүүлэх зорилгоор Тал бүр:
  - (а) энэ зүйлийн 1 дүгээр заалтад заасан үйл ажиллагааг явуулах тусгай зөвшөөрлийг үндэсний хууль тогтоомж болон энэхүү Протоколын зүйл, заалтад нийцүүлэн олгох, шинэчлэх, түдгэлзүүлэх, цуцлах болон/эсхүл хүчингүй болгох эрх бүхий байгууллага буюу байгууллагуудыг томилох эсхүл байгуулах;
  - (б) тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөлд өргөдөл гаргагчийн талаар холбогдох шаардлагатай мэдээллийг тусгахыг шаардах ба үүнд дараах мэдээллийг хамруулна:
    - (i) өргөдөл гаргагч нь хувь хүн бол түүний хувийн мэдээ, үүнд овог нэр, худалдааны нэр, бизнесийн бүртгэлийн дугаар (хэрэв байгаа бол), татварын бүртгэлийн дугаар (хэрэв байгаа бол) болон тухайн этгээдийг тодорхойлох бусад мэдээлэл;
    - (ii) өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол түүнтэй холбоотой мэдээлэл, үүнд хуулийн этгээдийн нэр, худалдааны нэр, бизнесийн бүртгэлийн дугаар, үүсгэн байгуулагдсан огноо болон газар, хуулийн этгээдийн толгой байгууллагын хаяг ба бизнесийн үйл ажиллагааг голлон явуулдаг газар, татварын бүртгэлийн дугаар, хуулийн этгээдийн дүрэм түүнтэй адилтгах бусад баримт бичгийн хуулбар, түүний салбар, захирлууд болон эрх бүхий төлөөлөгчдийн нэрс болон тухайн хуулийн этгээдийг тодорхойлох бусад мэдээлэл;
    - (iii) өргөдөл гаргагчийн үйлдвэрлэлийн нэгж(үүд)-ийн байршил, агуулахын байршил болон үйлдвэрлэлийн хүчин чадал;

- (iv) өргөдөлд дурдагдсан тамхин бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн тодорхойлолт, үүнд бүтээгдэхүүний нэр, барааны тэмдэгтийн дугаар (хэрэв байгаа бол), үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн загвар, брэнд, хийц ба серийн дугаар;
  - (v) үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийг хаана суурилуулж хэрэглэх тухай мэдээлэл;
  - (vi) гэмт хэрэг, зөрчилд холбогдож байсан тухай баримт;
  - (vii) холбогдох төлбөр тооцоо, бусад гүйлгээнд хэрэглэхээр төлөвлөсөн банкны дансны тухай бүрэн мэдээлэл болон төлбөр тооцооны талаарх бусад холбогдох мэдээлэл; болон
  - (viii) тамхин бүтээгдэхүүний үйлдвэрлэл эсхүл ханган нийлүүлэлт нь урьдчилан тооцоолсон эрэлт хэрэгцээнд таарч тохирч байгаа эсэхэд онцгой анхаарал хандуулан тамхин бүтээгдэхүүний зориулалт болон худалдаалахаар төлөвлөсөн зах зээлийн тодорхойлолт;
- (в) тусгай зөвшөөрлийн хураамжийг цуглуулах, хяналт тавих, түүнийг тусгай зөвшөөрлийн тогтолцоог үр дүнтэй удирдах эсхүл нийгмийн эрүүл мэнд болон холбогдох бусад үйл ажиллагаанд үндэсний хууль тогтоомжийн дагуу зарцуулах;
  - (г) тусгай зөвшөөрлийн тогтолцооны аливаа доголдол эсхүл зүй бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, мөрдөн шалгах талаар зохих арга хэмжээ авах;
  - (д) тусгай зөвшөөрөлд тогтмол үзлэг, шинэчлэл, хяналт эсхүл аудит хийх зэрэг арга хэмжээ авах;
  - (е) шаардлагатай гэж үзсэн үед тусгай зөвшөөрлийн дуусах хугацаа болон хугацаа сунгах өргөдөл гаргах хугацаа эсхүл өргөдлийн мэдээллийн шинэчлэх хугацааг тогтоох;
  - (ж) бизнесийн хаяг өөрчлөгдөх буюу тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаатай холбоотой аливаа томоохон өөрчлөлтийн талаар эрх бүхий байгууллагад урьдчилж мэдэгдэхийг тусгай зөвшөөрөл авсан хувь хүн, хуулийн этгээдэд үүрэг болгох;
  - (з) үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмж авсан эсхүл хэрэглээнээс гаргасан тухай эрх бүхий байгууллагад даруй мэдэгдэхийг тусгай зөвшөөрөл авсан хувь хүн, хуулийн этгээдэд үүрэг болгох; болон
  - (и) үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмж, түүний аливаа эд ангийг заавал эрх бүхий байгууллагын хяналтад дор устгах.
4. Тал бүр тусгай зөвшөөрөл горилогчоос энэхүү зүйлийн 3 дугаар заалтад заасан мэдээлэл, мөн эрх бүхий байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр нэг ч тусгай зөвшөөрлийг олгох ба/буюу шилжүүлэхийг хориглох арга хэмжээг авна.
5. Энэхүү Протокол хүчин төгөлдөр болсноос хойш таван жилийн дараа Талуудын уулзалтын ээлжит хуралдаанаар тамхин бүтээгдэхүүний үйлдвэрлэлд зайлшгүй шаардлагатай бөгөөд тодорхойлох боломжтой, улмаар үр дүнтэй хяналтын механизм бүрдүүлж болохуйц үндсэн орцыг тогтоох нотолгоонд суурилсан судалгаа явуулах арга хэмжээ авна. Энэхүү судалгаанд үндэслэн Талуудын уулзалтаас зохих арга хэмжээ авна.

## 7 ДУГААР ЗҮЙЛ

### ХӨНДЛӨНГИЙН СУДАЛГАА

1. Тал бүр үндэсний хууль тогтоомж болон ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын зорилтод нийцүүлэн тамхи, тамхин бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлтийн сүлжээт оролцдог бүх хувь хүн, хуулийн этгээдээс дараах арга хэмжээ авахыг шаардана:
  - (а) бизнесийн харилцаа тогтоохоос өмнө эсвэл бизнесийн харилцааны явцад хөндлөнгийн судалгаа хийх;
  - (б) борлуулалтад хяналт тавих замаар борлуулалтыг тухайн бүтээгдэхүүнийг худалдах эсхүл хэрэглэх гэж буй зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх; болон
  - (в) энэхүү Протоколоор хүлээсэн үүрэгт харшилсан үйл ажиллагаанд худалдан авагч оролцож байгаа талаарх аливаа нотолгоог эрх бүхий байгууллагад мэдээлэх.
2. Энэ зүйлийн 1 дэх заалтын дагуу үндэсний хууль тогтоомж болон ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын зорилтод нийцүүлэн хөндлөнгийн судалгаа хийхдээ худалдан авагчийг тодорхойлох дараах мэдээллийг олж авах, шинэчлэх талаар шаардлага тавина:
  - (а) тухайн хувь хүн, хуулийн этгээд 6 дугаар зүйлд заасны дагуу хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй эсэх;
  - (б) хэрэв худалдан авагч нь хувь хүн бол түүний овог нэр, худалдааны нэр, бизнесийн бүртгэлийн дугаар (хэрэв байгаа бол), татварын бүртгэлийн дугаар (хэрэв байгаа бол) болон түүний албан ёсны биеийн байцаалтын баталгаажуулалт;
  - (в) хэрэв худалдан авагч нь хуулийн этгээд бол түүнтэй холбоотой мэдээлэл, үүнд хуулийн этгээдийн нэр, худалдааны нэр, бизнесийн бүртгэлийн дугаар, үүсгэн байгуулагдсан огноо болон газар, хуулийн этгээдийн толгой байгууллагын хаяг ба бизнесийн үйл ажиллагааг голлон явуулдаг газар, татварын бүртгэлийн дугаар, хуулийн этгээдийн дүрэм түүнтэй адилтгах бусад баримт бичгийн хуулбар, түүний салбар, захирлууд болон эрх бүхий төлөөлөгчдийн нэрс болон тэдгээрийн албан ёсны биеийн байцаалтын баталгаажуулалт;
  - (г) тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн зориулалт болон худалдаалахаар төлөвлөсөн зах зээлийн тодорхойлолт; болон
  - (д) үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийг хаана суурилуулж хэрэглэх тухай мэдээлэл.
3. Энэ зүйлийн 1 дэх заалтын дагуу хөндлөнгийн судалгаа хийхдээ худалдан авагчийг тодорхойлох дараах мэдээллийг олж авах, шинэчлэх талаар шаардлага тавьж болно:
  - (а) гэмт хэрэг, зөрчилд холбогдож байсан тухай баримт; болон
  - (б) борлуулалтад хяналт тавих замаар борлуулалтыг тухайн бүтээгдэхүүнийг худалдах эсхүл хэрэглэх гэж буй зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх; болон
4. Тал бүр 1(в) заалтад заасан мэдээлэлд үндэслэн энэхүү Протоколоор хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээ авах ба үүнд тухайн худалдан авагчийг үндэсний хууль тогтоомжийн хүрээнд өөрийн нутаг дэвсгэр дээр хориотой худалдан авагч хэмээн зарлана.

## 8 ДУГААР ЗҮЙЛ

### МӨРДӨН ШАЛГАХ БА ХЯНАН ТОГТООХ

1. Ханган нийлүүлэлтийн сүлжээг найдвартай байлгах, тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааны мөрдөн шалгалтад туслах зорилгоор Талууд энэхүү Протоколыг хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дотор дэлхийн мөрдөн шалгах, хянан тогтоох дэглэм байгуулахыг зөвшөөрнө. Энэ нь ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын Нарийн бичгийн даргын газарт байрлаж бүх Талуудад хүртээмжтэй байх дэлхийн мэдээллийн солилцоог хариуцсан төв цэг болон үндэсний ба/буюу бүсийн мөрдөн шалгах ба хянан тогтоох тогтолцооноос бүрдэх ба Талуудад гаргасан хүсэлтийн дагуу холбогдох мэдээлэл олж авах боломж олгоно.
2. Тал бүр өөрийн үндэсний буюу бүсийн өвөрмөц хэрэгцээ, шилдэг туршлагыг харгалзан нутаг дэвсгэрт нь үйлдвэрлэгдсэн эсхүл импортоор орж ирсэн тамхин бүтээгдэхүүнийг мөрдөн шалгах, хянан тогтоох тогтолцоог бий болгоно.
3. Мөрдөн шалгах, хянан тогтоох тогтолцооны үйл ажиллагааг үр дүнтэй байлгах үүднээс Тал бүр код эсхүл тамга зэрэг үл давтагдах, найдвартай болон үл салах тэмдэг (цаашид «үл давтагдах тэмдэг»)-ийг янжуур тамхины нэгж хайрцаг болон бусад бүх сав, баглаа, боодол дээр тавьдаг болохыг энэхүү Протоколыг өөрийн улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш таван жилийн дотор, харин бусад тамхин бүтээгдэхүүний хувьд арван жилийн дотор шаардана.
- 4.1. Тал бүр энэ зүйлийн 3 дахь заалтад заасны дагуу дэлхийн мөрдөн шалгах, хянан тогтоох дэглэмийн хүрээнд дараах мэдээллийг шууд буюу тусгай холбоосын тусламжтай хүртээмжтэй байлгах шаардлага тавьж, тамхин бүтээгдэхүүний гарал үүсэл, тээвэрлэлтийн төлөвлөсөн замаас гажсан цэг (хэрэв хамааралтай бол)-ийг тодорхойлох, тамхин бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөн болон хууль зүйн статуст хяналт тавихад нь Талуудад дэмжлэг үзүүлнэ:
  - (а) үйлдвэрлэлийн огноо, байршил;
  - (б) үйлдвэр;
  - (в) тамхин бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хэрэглэсэн тоног төхөөрөмж;
  - (г) үйлдвэрлэлийн ээлж эсхүл цаг;
  - (д) үйлдвэрлэгчийн харьяа салбар бус анхны худалдан авагчийн нэр, нэхэмжлэх, захиалгын дугаар болон төлбөр тооцооны баримт;
  - (е) жижиглэнгээр борлуулахаар төлөвлөсөн зах зээл;
  - (ж) бүтээгдэхүүний тодорхойлолт;
  - (з) аливаа агуулахын хадгалалт болон тээвэрлэлт;
  - (и) мэдэгдэж буй дараагийн худалдан авагчийн тухай мэдээлэл; болон
  - (к) тээвэрлэлтийн төлөвлөсөн зам, тээвэрлэх огноо, тээвэрлэлтийн хүрэх газар, явах цэг болон ачаа хүлээн авагч.
- 4.2. Дээрх заалтын (а), (б), (ж) болон хамааралтай бол (е) заалтад заасан мэдээлэл нь үл давтагдах тэмдгийн бүрэлдэхүүн хэсэг болно.
- 4.3. Тэмдэглэгээ хийх үед (е) заалтад заасан мэдээлэл байхгүй бол Талууд ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын 15.2(а) заалтын дагуу энэхүү мэдээллийг оруулахыг шаардана.

5. Тал бүр тамхин бүтээгдэхүүний тухай энэ зүйлийн 4 дэх заалтад заасан мэдээллийг бүтээгдэхүүн үйлдвэрлэгдсэн даруйд нь, эсхүл аливаа үйлдвэрлэгч анхны тээвэрлэлтээ хийсэн үед нь, эсхүл нутаг дэвсгэрт нь импортоор орж ирсэн үед нь бүртгэхийг энэхүү зүйлд заасан хугацаанд нийцүүлэн шаардана.
6. Тал бүр энэ зүйлийн 5 дахь заалтад заасан мэдээллийг энэ зүйлийн 3 ба 4 дэх заалтад шаардсан ёсоор үл давтагдах тэмдэгтэй холбох замаар хүртээмжтэй байлгана.
7. Тал бүр энэ зүйлийн 5 дахь заалтад заасны дагуу бүртгэсэн мэдээлэл болон энэхүү мэдээллийг энэ зүйлийн 6 дахь заалтад заасны дагуу хүртээмжтэй болгож байгаа үл давтагдах тэмдгүүдийг тухайн Тал болон түүний эрх бүхий байгууллагуудын тогтоосон эсхүл зөвшөөрсөн форматаар хийнэ.
8. Тал бүр энэ зүйлийн 5 дахь заалтад заасан мэдээллийг энэ зүйлийн 9 дэх заалтад нийцүүлэн аюулгүй цахим стандарт интерфэйсээр дамжуулан өөрийн үндэсний ба/буюу бүсийн төв цэгээс дэлхийн мэдээллийн солилцоог хариуцсан төв цэгт хүртээмжтэй байлгана. Дэлхийн мэдээллийн солилцоог хариуцсан төв цэг нь Талуудын эрх бүхий байгууллагуудын жагсаалт хөтөлж, тэрхүү жагсаалтыг бүх Талуудад хүртээмжтэй болгоно.
9. Тал бүр эсхүл эрх бүхий байгууллага нь:
  - (а) дэлхийн мэдээллийн солилцоог хариуцсан төв цэгт хүсэлт гаргаж энэ зүйлийн 4 дэх заалтад заасан мэдээллийг цаг алдалгүй олж авах боломжоор хангагдана;
  - (б) зөвхөн тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг илрүүлэх, мөрдөн шалгахад шаардлагатай нөхцөлд энэхүү мэдээллийг авах хүсэлт гаргана;
  - (в) ямар нэгэн бодит шалтгаангүйгээр мэдээллээр хангахгүй байхаас зайлсхийнэ;
  - (г) энэ зүйлийн 4 дэх заалттай холбоотой мэдээллийн хүсэлтийг үндэснийхээ хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ; мөн
  - (д) солилцож буй аливаа мэдээллийг харилцан тохиролцсоны дагуу хамгаалж, нууцлалыг хангана.
10. Тал бүр үйлдвэрлэл, импорт, гаалийн хяналт, эсхүл онцгой албан татварын хяналтын цэгт холбогдох бүх татвар, төлбөр тооцоог барагдуулах хүртэл мөрдөн шалгах, хянан тогтоох тогтолцоог өргөжүүлэн хөгжүүлэхийг шаардана.
11. Талууд мөрдөн шалгах, хянан тогтоох шилдэг туршлага солилцох, хөгжүүлэх талаар хоорондоо болон эрх бүхий олон улсын байгууллагуудтай харилцан тохиролцсоны дагуу дараах чиглэлээр хамтран ажиллана:
  - (а) мөрдөн шалгах болон хянан тогтоох сайжруулсан технологи, үүнд мэдлэг, ур чадвар, чадавхи, туршлагыг хөгжүүлэх, дамжуулах болон олж авахад дэмжлэг үзүүлэх;
  - (б) хэрэгцээгээ илэрхийлсэн Талд сургалт болон чадавх бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх; болон
  - (в) энэ зүйлийн 4 дэх заалтад заасан мэдээллийг хүртээмжтэй болгох зорилгоор тамхины хайрцаг болон тамхин бүтээгдэхүүний нэгж хайрцаг дээр тэмдэглэгээ хийх, шалгах технологийг цаашид хөгжүүлэх.
12. Талууд хүлээсэн үүргээ тамхи үйлдвэрлэгчээр гүйцэтгүүлэх буюу түүнд шилжүүлэхийг хориглоно.

13. Тал бүр түүний эрх бүхий байгууллагууд мөрдөн шалгах, хянан тогтоох дэглэмийг хэрэгжүүлэхдээ тамхи үйлдвэрлэгч болон түүний ашиг сонирхлыг төлөөлж буй этгээдтэй зөвхөн энэхүү зүйлийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай хэмжээнд харилцахыг шаардана.
14. Тал бүр энэхүү зүйлийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотой аливаа зардлыг даахыг тамхи үйлдвэрлэгчээс шаардаж болно.

## 9 ДҮГЭЭР ЗҮЙЛ

### БҮРТГЭЛ, ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ХӨТЛӨЛТ

1. Тал бүр тамхи, тамхин бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлтийн сүлжээт оролцдог хувь хүн, хуулийн этгээдээс холбогдох бүхий л гүйлгээний бүртгэл, тайлан мэдээг бүрэн, үнэн зөв хөтлөхийг шаардана. Энэхүү бүртгэл, тайлан мэдээ нь тамхин бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашигласан бүх материалыг бүрэн тооцох боломж олгохуйц байх ёстой.
2. Тал бүр 6 дугаар зүйлийн дагуу тусгай зөвшөөрөл авсан хувь хүн, хуулийн этгээдээс дараах мэдээллийг хүсэлтийн дагуу эрх бүхий байгууллагад гаргаж өгөхийг шаардана:
  - (а) зах зээлийн багтаамж, чиг хандлага, цаашдын төлөв болон холбогдох бусад мэдээлэл; болон
  - (б) тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эзэмшил, хадгалалт, хяналтад байгаа бөгөөд дамжин өнгөрөх сүлжээ эсхүл татварт түр саатуулснаас татварын болон гаалийн баталгаат агуулахад хяналтанд байгаа бүх тамхин бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн тоо ширхэг хүсэлт гаргасан өдрийн байдлаар.
3. Экспортлох зорилгоор тухайн Талын нутаг дэвсгэрт борлуулсан эсхүл үйлдвэрлэсэн, эсхүл татвараас чөлөөлөгдөн тухайн Талын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч буй тамхин бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмж тус нутаг дэвсгэрээс ачигдах үед тухайн Талын эрх бүхий байгууллагад тэдний хүсэлтээр дараах мэдээллийг (холбогдох дэд бүтэц байгаа бол электрон хэлбэрээр) гаргаж өгөхийг 6 дугаар зүйлийн дагуу тусгай зөвшөөрөл авсан этгээдээс шаардана:
  - (а) бүтээгдэхүүн тусгай зөвшөөрөл бүхий этгээдийн биет хяналтаас гарч, тээвэрлэгдсэн огноо;
  - (б) тээвэрлэгдсэн бүтээгдэхүүний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл (брэнд, тоо хэмжээ, баталгаат агуулах зэрэг);
  - (в) тээвэрлэлтийн зам, хүрэх газар;
  - (г) тээвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах хувь хүн, хуулийн этгээдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
  - (д) тээвэрлэлтийн хэлбэр, тээвэрлэгчийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
  - (е) ачаа бараа төлөвлөсөн газраа хүрэх тооцоолсон огноо; болон
  - (ж) жижиглэнгээр борлуулах эсхүл ашиглахаар төлөвлөсөн зах зээл.
4. Тал бүр арилжааны бус зорилгоор тамхины ургамал тариалж буй уламжлалт тариаланчдаас бусад тамхины тариаланч болон жижиглэн худалдаа эрхлэгчдээс бүхий л гүйлгээний тайлан, мэдээг үндэсний хууль тогтоомжийн дагуу бүрэн, нягт нямбай хөтлөхийг шаардана.

5. Тал бүр энэ зүйлийн 1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор бүх бүртгэл тайланд тавих дараах шаардлагыг хэрэгжүүлэх хууль тогтоох, гүйцэтгэх, захиргааны болон холбогдох бусад үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:
  - (а) дөрвөн жилээс багагүй хугацаагаар хадгалах;
  - (б) эрх бүхий байгууллагуудад нээлттэй байлгах; болон
  - (в) эрх бүхий байгууллагуудаас шаардсан форматаар хөтлөх.
6. Тал бүр үндэсний хууль тогтоомжийн хүрээнд энэхүү зүйлийн дагуу хөтөлсөн бүх тайланд байгаа мэдээллийг бусад Талтай хуваалцах тогтолцоо бүрдүүлнэ.
7. Талууд бүртгэл тайлан хөтлөх сайжруулсан тогтолцоог хөгжүүлэх талаар хоорондоо болон эрх бүхий олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах талаар хүчин чармайлт гаргана.

## 10 ДУГААР ЗҮЙЛ

### АЮУЛГҮЙ БАЙДАЛ БОЛОН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

1. Тал бүр үндэсний хууль тогтоомж, ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын зорилтуудад нийцүүлэн тамхин бүтээгдэхүүнийг хууль бус худалдааны сувагт орохоос урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээ, үүнд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг 6 дугаар зүйлд хамаарах бүх хувь хүн, хуулийн этгээдээс шаардана:
  - (а) эрх бүхий байгууллагад дараах мэдээллийг өгөх:
    - (i) үндэсний хууль тогтоомжид заасан бэлэн мөнгөний хил дамнасан шилжүүлэг эсхүл хил дамнасан биет төлбөр тооцоо;
    - (ii) бүх «сэжигтэй гүйлгээ»; болон
  - (б) тамхин бүтээгдэхүүн буюу үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийг зөвхөн жижиглэнгээр борлуулах эсхүл ашиглахаар төлөвлөсөн зах зээлийн эрэлтэд нийцсэн хэмжээгээр хангах.
2. Тал бүр үндэсний хууль тогтоомж, ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын зорилтод нийцүүлэн 6 дугаар зүйлд заасан хувь хүн буюу хуулийн этгээдийн хийж буй гүйлгээний төлбөр тооцоог зөвхөн нэхэмжилсэн мөнгөн тэмдэгтээр болон хэмжээгээр хийхийг шаардах бөгөөд тухайн бүтээгдэхүүнийг борлуулахаар төлөвлөсөн зах зээл оршин байгаа нутаг дэвсгэрт санхүүгийн байгууллагаас төлбөр тооцоо хийхээр зөвшөөрсөн төлбөрийн аргыг хэрэглэхийг зөвшөөрөх ба мөнгөн гуйвуулгын бусад тогтолцоог ашиглахгүй байхыг шаардана.
3. Тал нь 6 дугаар зүйлд заасан хувь хүн буюу хуулийн этгээдээс өөрийн нутаг дэвсгэр дээр тамхин бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашигласан материалын төлбөр тооцоог зөвхөн нэхэмжилсэн мөнгөн тэмдэгтээр болон хэмжээгээр хийхийг шаардаж болох бөгөөд тухайн бүтээгдэхүүнийг борлуулахаар төлөвлөсөн зах зээл оршин байгаа нутаг дэвсгэрт санхүүгийн байгууллагаас төлбөр тооцоо хийхээр зөвшөөрсөн төлбөрийн аргыг хэрэглэхийг зөвшөөрөх ба мөнгөн гуйвуулгын бусад тогтолцоог ашиглахгүй байхыг шаардаж болно.
4. Тал бүр энэхүү зүйлийг зөрчсөн аливаа зохих эрүүгийн, иргэний эсхүл захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дагуу тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх эсхүл хүчингүй болгох зэрэг үр дүнтэй, тэнцвэртэй хариуцлага хүлээлгэнэ.



## **11 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

### **ИНТЕРНЭТ, ЦАХИЛГААН ХОЛБОО ЭСХҮЛ ШИНЭЭР ХӨГЖИЖ БУЙ БУСАД ТЕХНОЛОГИОР ДАМЖУУЛАН ХИЙХ ХУДАЛДАА**

1. Тал бүр тамхин бүтээгдэхүүнтэй холбоотой аливаа гүйлгээг интернэт, цахилгаан холбоо эсхүл шинээр хөгжиж буй бусад дэвшилтэт технологиор дамжуулан хийж буй бүх хувь хүн, хуулийн этгээдээс энэхүү Протоколд заасан бүх холбогдох үүргийг биелүүлэхийг шаардана.
2. Тал бүр тамхин бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдааг интернэт, цахилгаан холбоо эсхүл шинээр хөгжиж буй бусад дэвшилтэт технологиор дамжуулан явуулахыг хориглох талаар арга хэмжээ авна.

## **12 ДУГААР ЗҮЙЛ**

### **ЧӨЛӨӨТ БУС БА ОЛОН УЛСЫН ДАМЖИН ӨНГӨРҮҮЛЭЛТ**

1. Тал бүр энэхүү Протоколыг өөрийн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр болсноос хойш гурван жилийн дотор чөлөөт бүсүүдэд тамхи, тамхин бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон худалдаанд энэ Протоколд заасан холбогдох бүх арга хэмжээг ашиглан үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлнэ.
2. Мөн контейнер болон бусад ижил төстэй тээвэрлэлтийн нэгжид тамхин бүтээгдэхүүнийг тамхин бус бүтээгдэхүүнтэй хольж чөлөөт бүсээс гаргахыг хориглоно.
3. Тал бүр тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаанаас сэргийлэх зорилгоор өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тамхин бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн олон улсын тээвэрлэлтийг хянах, баталгаажуулах арга хэмжээг үндэсний хууль тогтоомж, энэхүү Протоколын зүйл заалтад нийцүүлэн авч хэрэгжүүлнэ.

## **13 ДУГААР ЗҮЙЛ**

### **ТАТВАРГҮЙ ХУДАЛДАА**

1. Тал бүр ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын 6 дугаар зүйлийг харгалзан аливаа татваргүй худалдаанд энэхүү Протоколын холбогдох заалтуудыг хэрэглэх үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
2. Энэхүү Протокол хүчин төгөлдөр болсноос хойш таван жилийн дотор Талуудын уулзалтын ээлжит хуралдаанаар татваргүй худалдаатай холбоотой тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааны цар хүрээг тогтоох нотолгоонд суурилсан судалгаа явуулах арга хэмжээ авна. Энэхүү судалгаанд үндэслэн Талуудын уулзалтаас зохих арга хэмжээ авна.

## IV ХЭСЭГ: ГЭМТ ХЭРЭГ

### 14 ДҮГЭЭР ЗҮЙЛ

#### ХУУЛЬ БУС ҮЙЛДЭЛ, ТЭР ДУНДАА ЭРҮҮГИЙН ГЭМТ ХЭРЭГ

1. Тал бүр өөрийн эрхзүйн үндсэн зарчимд нийцүүлэн дотоодын хууль тогтоомжид дараах үйлдлийг хууль бус хэмээн тогтоох талаар шаардлагатай гэж үзсэн зохих ёсны хууль зүйн болон бусад арга хэмжээг авна:
  - (а) энэхүү Протоколын зүйл заалтад харшилсан тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, бөөний худалдаа, брокерийн үйл ажиллагаа, борлуулалт, тээвэрлэлт, түгээлт, хадгалалт, импорт буюу экспортын үйл ажиллагаа эрхлэх;
  - (б) (i) тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийг холбогдох татварын төлбөр, татвар, татварын тэмдэг, үл давтагдах тэмдэг эсхүл бусад шаардлагатай шошго, тэмдэггүйгээр үйлдвэрлэх, бөөнөөр худалдах, брокерийн үйл ажиллагаанд хамруулах, борлуулах, тээвэрлэх, түгээх, хадгалах, зөөвөрлөх, импортлох эсхүл экспортлох;
  - (ii) тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн (б)(i)-д зааснаас бусад хэлбэрээр хууль бус худалдаа эрхлэх;
  - (в) (i) тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийг бусад хэлбэрээр хууль бусаар үйлдвэрлэх, эсхүл хуурамч татварын тэмдэг, үл давтагдах тэмдэг буюу бусад шаардлагатай шошго, тэмдэг бүхий тамхин бүтээгдэхүүний сав баглаа, боодол үйлдвэрлэх;
  - (ii) хууль бусаар үйлдвэрлэсэн тамхи, тамхин бүтээгдэхүүн, эсхүл хуурамч татварын тэмдэг ба/буюу бусад шаардлагатай шошго, тэмдэг бүхий тамхин бүтээгдэхүүн, эсхүл хууль бусаар үйлдвэрлэсэн үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийг бөөнөөр худалдах, брокерийн үйл ажиллагаанд хамруулах, борлуулах, тээвэрлэх, түгээх, хадгалах, зөөвөрлөх, импортлох эсхүл экспортлох;
  - (г) тамхин бүтээгдэхүүнийг нуун дарагдуулах зорилгоор ханган нийлүүлэлтийн сүлжээнд тамхин бүтээгдэхүүнийг тамхин бус бүтээгдэхүүнтэй холих;
  - (д) энэхүү Протоколын 12.2-т заасныг зөрчин тамхин бүтээгдэхүүнийг тамхин бус бүтээгдэхүүнтэй холих;
  - (е) энэхүү Протоколын зүйл заалтад харшилсан интернэт, цахилгаан холбоо эсхүл шинээр хөгжиж буй бусад дэвшилтэт технологид суурилсан тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн худалдаа эрхлэх;
  - (ж) 6 дугаар зүйлд заасны дагуу холбогдох зөвшөөрөл бүхий эсхүл түүнтэй адилтгах эрх бүхий этгээд нь 6 дугаар зүйлд заасны дагуу холбогдох зөвшөөрөл, эсхүл түүнтэй адилтгах эрх авсан байх ёстой боловч аваагүй этгээдээс тамхи, тамхин бүтээгдэхүүн, эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийг олж авах;
  - (з) тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн хууль бус худалдаанаас урьдчилан сэргийлэх, саатуулах, илрүүлэх, мөрдөн байцаах, эсхүл түүнийг устгахтай холбоотойгоор ажил үүргээ гүйцэтгэхэд нь төрийн албан хаагч эсхүл бусад эрх бүхий этгээдэд саад учруулах;

- (и) (i) тамхи, тамхин бүтээгдэхүүн, эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн хууль бус худалдаанаас урьдчилан сэргийлэх, саатуулах, илрүүлэх, мөрдөн байцаах, эсхүл түүнийг устгахтай холбоотойгоор ажил үүргээ гүйцэтгэж буй төрийн албан хаагч эсхүл бусад эрх бүхий этгээдэд худал, төөрөгдүүлсэн буюу бүрэн бус мэдүүлэг өгөх, эсхүл шаардлагатай мэдээллийг өгөхгүй байх;
  - (ii) албан ёсны баримтад тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн тодорхойлолт, тоо хэмжээ, үнийн дүн буюу энэхүү Протоколд заасан бусад мэдээллийг дараах зорилгоор худал мэдүүлэх:
    - (а) холбогдох татвар, татварын төлбөр болон бусад төлбөрийг хураамжийг төлөхөөс зайлсхийх; эсхүл
    - (б) тамхи, тамхин бүтээгдэхүүн, эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн хууль бус худалдаанаас урьдчилан сэргийлэх, саатуулах, илрүүлэх, мөрдөн байцаах, эсхүл түүнийг устгах арга хэмжээг эсэргүүцэх;
  - (iii) энэхүү Протоколд заасан тайлан хөтлөхгүй байх, эсхүл худал тайлан хөтлөх; болон
- (к) энэхүү зүйлийн 2 дугаар заалтад заасанчлан гэмт хэрэг гэж тодорхойлсон аливаа хууль бус үйлдлээс олсон мөнгийг «угаах».
2. Тал бүр дотоодын хууль, тогтоомжийн үндсэн зарчимд нийцүүлэн энэхүү зүйлийн 1 дэх заалтад заасан буюу энэхүү Протоколын зүйл заалтад харшилсан тамхи, тамхин бүтээгдэхүүн, эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн хууль бус худалдаатай холбоотой аливаа хууль бус үйлдлээс алийг нь эрүүгийн гэмт хэрэгт тооцох, мөн тэдгээрт ногдуулах эрхзүйн болон бусад шийтгэлийн арга хэмжээг тогтооно.
  3. Тал бүр Протоколын Нарийн бичгийн даргын газарт энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтад заасан хууль бус үйлдлийн алийг нь эрүүгийн гэмт хэрэгт тооцохоор болсноо мэдэгдэж, 2 дугаар заалтыг албажуулсан хуулийн хуулбар буюу тодорхойлолт, мөн эдгээрт нэмэлт өөрчлөлт орох бүрт нэмэлт өөрчлөлтийг хүргүүлэх арга хэмжээ авна.
  4. Тамхи, тамхин бүтээгдэхүүн, эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн хууль бус худалдаатай тэмцэх талаар олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Талууд нэгдэн орсон олон улсын конвенцуудад нийцүүлэн мөнгө «угаах», эрхзүйн харилцан туслалцаа үзүүлэх, гэмт этгээдийг шилжүүлэн өгөх талаар өөрийн үндэсний хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулж, энэхүү Протоколын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлнэ.

## 15 ДУГААР ЗҮЙЛ

### ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХАРИУЦЛАГА

1. Тал бүр энэхүү Протоколын 14 дүгээр зүйлд заасан хууль бус үйлдэл үйлдсэн хуулийн этгээдэд өөрийн улсын эрх зүйн зарчимд нийцүүлэн хариуцлага тогтоох талаар шаардлагатай гэж үзсэн бүхий л арга хэмжээг авна.
2. Хуулийн этгээдэд эрүүгийн, иргэний эсхүл захиргааны хариуцлага ногдуулах эсэх нь Тал бүрийн эрх зүйн зарчмын хэрэг байна.

3. Энэхүү хариуцлага нь үндэсний хууль тогтоомж болон энэхүү Протоколын 14 дүгээр зүйлд нийцүүлэн хууль бус үйлдэл эсхүл эрүүгийн гэмт хэрэгт ногдуулсан хувь хүний хариуцлагыг хязгаарлахгүй.

## **16 ДУГААР ЗҮЙЛ**

### **ХАРИУЦЛАГА БА ШҮҮХ АЖИЛЛАГАА**

1. Тал бүр энэхүү Протоколын 14 дүгээр зүйлд заасан дагуу тогтоосон хууль бус үйлдэл эсхүл эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн хувь хүн, хуулийн этгээдэд үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн шаардлагатай гэж үзсэн үр дүнтэй, гэмт үйлдэлд нь тохирсон эрүүгийн эсхүл эрүүгийн бус, үүнд мөн мөнгөн хариуцлага ногдуулна.
2. Тал бүр хууль бус үйлдэл, үүнд энэхүү Протоколын 14 дүгээр зүйлд заасан хууль бус үйлдэл эсхүл эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд дотоодын хууль тогтоомжийн дагуу хууль сахиулах арга хэмжээг авахдаа тухайн арга хэмжээг аль болох үр дүнтэй байлгах, ийм төрлийн хууль бус ажиллагааг захиалах, давтан үйлдэх явдал гаргахгүй байх нөхцөл бүрдүүлэхийг эрмэлзэнэ.
3. Гэмт хэргийг тодорхойлох, холбогдох хууль зүйн хамгаалалт эсхүл үйлдлийн хууль ёсны эсэхийг хянах эрх зүйн зарчим нь Талуудын дотоодын хууль тогтоомжийн бүрэн эрхэд хамаарах бөгөөд гэмт этгээдийг яллах, шийтгэх асуудлыг дурдсан хуулийн дагуу хэрэгжүүлэх зарчмыг энэхүү Протоколын аль ч заалт хөндөхгүй.

## **17 ДУГААР ЗҮЙЛ**

### **ХУРААН АВАХ ТӨЛБӨР**

Талууд өөрийн дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн хураагдсан тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгч, түгээгч, импортлогч эсхүл экспортлогчид алдагдсан татвар болон төлбөрийн хувь хэмжээгээр төлбөр ногдуулах эрхийг холбогдох эрх бүхий байгууллагад олгох эрх зүйн болон бусад шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

## **18 ДУГААР ЗҮЙЛ**

### **УСТГАХ**

Хураагдсан бүх тамхи, тамхин бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийг үндэсний хууль тогтоомжийн дагуу хаях эсхүл байгаль орчинд ээлтэй арга ашиглан боломжийн хэрээр жижиглэн устгана.

## **19 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

### **МӨРДӨН БАЙЦААХ ТУСГАЙ АРГА**

1. Тал бүр тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн хууль бус худалдаатай үр дүнтэй тэмцэх зорилгоор дотоодын эрх зүйн тогтолцооны үндсэн зарчимд нийцүүлэн өөрийн улсын нутаг дэвсгэрт хяналттай түгээлтийг ашиглаж, шаардлагатай гэж үзвэл эрх бүхий байгууллагаас цахим болон бусад хэлбэрийн мөрдөн шалгах болон нууц ажиллагааны тусгай аргыг хэрэглэх арга хэмжээг авна.

2. 14 дүгээр зүйлд заасан эрүүгийн гэмт хэргийг мөрдөн байцаах зорилгоор олон улсын түвшний хамтын ажиллагааны хүрээнд энэ зүйлийн 1 дэх заалтад дурдсан аргыг хэрэглэхийн тулд Талууд шаардлагатай үед холбогдох хоёр талт, эсхүл олон талт хэлэлцээр байгуулахыг хөхиүлэн дэмжинэ.
3. Энэ зүйлийн 2 дахь заалтад заасан хэлэлцээр эхсүл зохицуулалт байхгүй бол олон улсын түвшинд ийм арга хэрэглэх шийдвэрийг хэрэг тус бүрээр гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд санхүүгийн зохицуулалт хийх болон хэргийн харъяаллыг тогтоох талаар холбогдох Талууд ойлголцолд хүрч болно.
4. Талууд энэ салбар дахь олон улсын хамтын ажиллагаа, тусламжийн ач холбогдол болон хэрэгцээг хүлээн зөвшөөрч, энэ зүйлийн зорилтод хүрэх чадавхийг хөгжүүлэх талаар бие биетэйгээ болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.

## **V ХЭСЭГ: ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА**

### **20 ДУГААР ЗҮЙЛ**

#### **ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ**

1. Энэхүү Протоколын зорилтот хүрэх, мөн ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцоор хүлээсэн тайлагнах үүргээ биелүүлэх үүднээс Талууд дотоодын хууль тогтоомжийн хүрээнд дараах асуудлаар холбогдох мэдээллийг солилцоно:
  - (а) хураан авсан тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл, тоо ширхэг, үнийн дүн, бүтээгдэхүүний танилцуулга, үйлдвэрлэлийн хугацаа болон байршил, зайлсхийсэн татварын хэмжээ;
  - (б) тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн импорт, экспорт, дамжин өнгөрөх тээвэр, татвартай болон татваргүй худалдаа, үйлдвэрлэлийн тоо хэмжээ эсхүл үнийн дүн;
  - (в) тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн хууль бус худалдааны хандлага, нуун дарагдуулах арга, үйл ажиллагааны аргачлал; болон
  - (г) Талуудын харилцан тохиролцсон холбогдох бусад мэдээлэл.
2. Мэдээлэл цуглуулах болон харилцан солилцох чадавхийг бэхжүүлэх зорилгоор Талууд хоорондоо болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.
3. Мэдээллийг дамжуулж буй Тал өөрөөр мэдэгдсэнээс бусад тохиолдолд энэхүү мэдээллийг нууц, зөвхөн Талуудын хүрээнд ашиглах мэдээлэл гэж ойлгоно.

### **21 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

#### **ПРОТОКОЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ**

1. Талууд тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн хууль бус худалдааг илрүүлэх, мөрдөн шалгахад хэрэгтэй баримт, нотолгоо болохуйц дараах мэдээллийг өөрийн санаачилгаар эсхүл аль нэг Талын гаргасан хүсэлтээр дотоодын хууль тогтоомж болон холбогдох олон улсын гэрээ хэлэлцээрт нийцүүлэн харилцан солилцоно:
  - (а) холбогдох хувь хүн, хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн тухай мэдээлэл;
  - (б) тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн хууль бус худалдаанд холбогдсон хувь хүн, хуулийн этгээдийг тогтоох, хяналт тавих, мөрдөн шалгахад шаардлагатай мэдээлэл;
  - (в) мөрдөн байцаалт, шүүхэд хянах ажиллагааны тухай мэдээлэл;
  - (г) тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн импорт, экспортын төлбөр, татваргүй худалдааны тухай мэдээлэл; болон
  - (д) тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн хураасан тухай мэдээлэл (үүнд тохиолдлын тухай лавлагаа, тоо хэмжээ, үнийн дүн, бүтээгдэхүүний танилцуулга, хэрэгт холбогдсон этгээдүүд, үйлдвэрлэлийн хугацаа болон байршил) болон үйл ажиллагааны аргачлал (үүнд тээвэрлэлтийн арга, нуун дарагдуулах арга, маршрут болон илрүүлэлт).

2. Энэхүү зүйлийн хүрээнд Талуудаас авсан мэдээллийг зөвхөн энэхүү Протоколын зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ашиглана. Мэдээллийг дамжуулж буй Талын зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулж болохгүйг Талууд онцгойлон дурдаж болно.

## **22 ДУГААР ЗҮЙЛ**

### **МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ: МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ, ХАМГААЛАЛ**

1. Тал бүр 20, 21 болон 24 дүгээр зүйлд заасан мэдээллийг хүргүүлэх эрх бүхий үндэсний байгууллагыг томилох бөгөөд ийнхүү томилсон тухайгаа Конвенцын нарийн бичгийн даргын газраар уламжлан Протоколын Талуудад мэдэгдэнэ.
2. Энэхүү Протоколын хүрээнд солилцсон мэдээллийн нууцлалыг дотоодын хууль тогтоомжоор хамгаална. Талууд харилцан тохиролцсон ёсоор солилцсон аливаа мэдээллийн нууцлалыг хамгаална.

## **23 ДУГААР ЗҮЙЛ**

### **ДЭМЖЛЭГ БА ХАМТЫН АЖИЛЛАГАА: ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН АСУУДЛААРХ СУРГАЛТ, ТЕХНИКИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХАМТЫН АЖИЛЛАГАА**

1. Талууд харилцан тохиролцсон ёсоор энэхүү Протоколын зорилтод хүрэхийн тулд хоорондоо болон/ эсхүл эрх бүхий олон улсын болон бүс нутгийн байгууллагуудтай шинжлэх ухаан, техник, технологийн асуудлаар сургалт зохион байгуулах, техникийн дэмжлэг үзүүлэх зэргээр хамтран ажиллана. Энэхүү хамтын ажиллагаа нь мэдээлэл цуглуулах, хууль сахиулах, мөрдөн шалгах болон хянан тогтоох, мэдээллийн менежмент, хувийн мэдээг хамгаалах, хорио цээр, цахим мөрдөн шалгалт, шүүх эмнэлгийн шинжилгээ, эрх зүйн харилцан туслалцаа, гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх чиглэлээр туршлага, тохиромжтой технологийг солилцох хэлбэртэй байж болно.
2. Талууд энэхүү Протоколын оролцогч хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтийн орнуудын хэрэгцээг анхааралдаа авч шинжлэх ухаан, техник, технологийн асуудлаарх сургалт, техникийн дэмжлэг болон хамтын ажиллагааг дэмжих үүднээс хоёр талт, олон талт болон бусад хэлэлцээр, зохицуулалтыг хийнэ.
3. Талууд хураагдсан тамхи, тамхин бүтээгдэхүүний газар зүйн тодорхой байршлыг тогтоох боломжийг судлах, хөгжүүлэх талаар хамтран ажиллана.

## **24 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

### **ДЭМЖЛЭГ БА ХАМТЫН АЖИЛЛАГАА: ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН БАЙЦААХ, ШҮҮХЭД ХЯНАХ**

1. Талууд дотоодын хууль тогтоомжийн хүрээнд тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн хууль бус худалдаанд холбогдсон хувь хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, мөрдөн шалгах, прокурорт хянан шалгах болон ял шийтгэл ногдуулах асуудлаар олон талт, бүс нутгийн болон хоёр талт хамтын ажиллагааг бэхжүүлэхэд бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.
2. Тал бүр тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн хууль бус худалдаатай тэмцэх чиг үүрэг бүхий захиргааны, зохицуулалтын, хууль сахиулах болон бусад эрх бүхий байгууллага (мөн дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бол шүүх эрх мэдлийн байгууллага) нь холбогдох

мэдээллийг үндэсний болон олон улсын түвшинд дотоодын хууль тогтоомжид заасан нөхцөлийн хүрээнд солилцож, хамтран ажиллах нөхцөл бүрдүүлнэ.

## **25 ДУГААР ЗҮЙЛ**

### **БҮРЭН ЭРХТ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ**

1. Талууд энэхүү Протоколоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ улс орнуудын бүрэн эрхт, тэгш байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдлын зарчимд нийцүүлэн бусад улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох зарчмыг баримтална.
2. Энэхүү Протокол нь Талуудыг өөр улсын нутаг дэвсгэр дээр шүүн таслах ажиллагаа явуулах болон тухайн улсын хуулиар зөвхөн тус улсын эрх бүхий байгууллагын бүрэн эрхэд хамаарах чиг үүргийг гүйцэтгэх эрх олгохгүй.

## **26 ДУГААР ЗҮЙЛ**

### **ХЭРГИЙН ХАРЬАЛАЛ**

1. Тал бүр 14 дүгээр зүйлд заасны дагуу тогтоогдсон эрүүгийн гэмт хэргийн харьяаллыг өөрийн мэдэлд байлгах шаардлагатай арга хэмжээг дараах тохиолдолд авна:
  - (а) гэмт хэрэг тухайн Талын нутаг дэвсгэрт нь үйлдэгдсэн; эсхүл
  - (б) гэмт хэрэг нь тухайн Талын төрийн далбааг мандуулсан хөлөг онгоцон дээр, эсхүл тухайн Талын хуулийн дагуу бүртгэгдсэн агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдсэн.
2. Дараах тохиолдолд 25 дугаар зүйлийн дагуу гэмт хэргийн харьяаллыг өөрийн мэдэлд байлгах арга хэмжээ авч болно:
  - (а) хэрэг зөрчил тухайн Талын эсрэг үйлдэгдсэн;
  - (б) хэрэг зөрчлийг тухайн Талын иргэн эсхүл түүний нутаг дэвсгэр дээр байнга оршин сууж буй харьяалалгүй этгээд үйлдсэн;
  - (в) хэрэг зөрчил нь 14 дүгээр зүйлд заасны дагуу тогтоосон гэмт хэрэг бөгөөд тухайн Талын нутаг дэвсгэрт үйлдэх гэмт хэргийг санхүүжүүлэх зорилгоор нутаг дэвсгэрээс нь гадна үйлдэгдсэн.
3. 30 дугаар зүйлийн заалтыг сахих үүднээс сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа бөгөөд түүнийг тухайн улсын аль нэг үндэстэн гэсэн үндэслэлээр нөгөө Талд шилжүүлэхгүй тохиолдолд Тал бүр гэмт хэргийн харьяаллыг өөрийн мэдэлд байлгах арга хэмжээ авна.
4. Тал бүр сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа бөгөөд түүнийг шилжүүлэхгүй тохиолдолд 14 дүгээр зүйлд заасны дагуу тогтоосон гэмт хэргийн харьяаллыг өөрийн мэдэлд байлгах арга хэмжээ авч болно.
5. Хэрэв аль нэг Тал энэ зүйлийн 1, 2 дахь заалтад заасны дагуу хэргийг шалгах явцад нэг ба түүнээс олон өөр Тал ижил зөрчлийн мөрөөр мөрдөн шалгах, прокурорын болон шүүхийн ажиллагаа явуулж байгаа талаар мэдээлэл авах буюу бусад байдлаар олж мэдсэн тохиолдолд тэдгээр Талуудын эрх бүхий байгууллагууд авч буй арга хэмжээгээ зохицуулах талаар хоорондоо зөвлөлдөнө.
6. Олон улсын нийтлэг эрх зүйн хэм хэмжээнд хохирол учруулахгүйгээр Талууд дотоодын хуулийн дагуу эрүүгийн шүүн таслах ажиллагаа явуулахыг энэхүү Протокол хориглохгүй.



## 27 ДУГААР ЗҮЙЛ

### ХУУЛЬ САХИН БИЕЛҮҮЛЭХ ТАЛААРХ ХАМТЫН АЖИЛЛАГАА

1. Тал бүр дотоодын хууль тогтоомж, захиргааны тогтолцоонд нийцүүлэн дараах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлнэ:
  - (а) 14 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлийн бүхий л асуудалтай холбоотой мэдээллийн түргэн шуурхай, найдвартай солилцоог хангах зорилгоор эрх бүхий байгууллага, агентлаг болон үйлчилгээ хоорондын харилцаа холбооны сувгийг сайжруулах, шаардлагатай бол байгуулах;
  - (б) эрх бүхий байгууллага, агентлаг, гааль, цагдаа болон бусад хууль сахиулах байгууллагуудын хоорондын үр дүнтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх;
  - (в) 14 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг, зөрчилд хамаарах тодорхой хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахтай холбоотойгоор бусад Талтай дараах асуудлаар хамтран ажиллах:
    - (i) тухайн гэмт хэрэгт холбогдуулан сэжиглэгдэж буй этгээдийн тухай мэдээлэл, байршил болон үйл ажиллагаа, эсхүл бусад холбоотой хүмүүсийн байршил;
    - (ii) гэмт хэргээс олсон орлого эсхүл тухайн гэмт хэргийг санхүүжүүлснээр олж авсан хөрөнгийн шилжилт хөдөлгөөн; болон
    - (iii) тухайн гэмт хэргийг үйлдэхэд хэрэглэсэн, эсхүл хэрэглэхээр төлөвлөсөн тоног төхөөрөмж болон бусад арга хэрэгсэл, эд хөрөнгийг шилжүүлэх ажиллагаа;
  - (г) сорилт, шинжилгээ эсхүл мөрдөн шалгах зорилгод хэрэгтэй эд юмс, бодисоор зохих үед нь хангах;
  - (д) эрх бүхий байгууллага, агентлаг болон үйлчилгээний хоорондын үр дүнтэй зохицуулалтыг хангах, холбогдох Талуудын хооронд хоёр талт хэлэлцээр байгуулах, Талуудыг холбох асуудал хариуцсан ажилтныг ажиллуулах зэргээр боловсон хүчин болон бусад мэргэжилтнийг солилцох явдлыг дэмжих;
  - (е) хувь хүн, хуулийн этгээд тухайн гэмт хэргийг үйлдэхдээ хэрэглэсэн тээврийн хэрэгсэл болон зам, өөрчилсөн эсхүл хуурамч бичиг баримт эсхүл үйл ажиллагаагаа нуун дарагдуулах бусад арга зэрэг тодорхой арга, ажиллагааны талаарх холбогдох мэдээллийг бусад Талтай харилцан солилцох; болон
  - (ж) 14 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг эрт илрүүлэх зорилгоор захиргааны болон бусад арга хэмжээг зохицуулах, холбогдох мэдээллийг харилцан солилцох.
2. Энэхүү Протоколыг хэрэгжүүлэх үүднээс Талууд хууль сахиулах байгууллага хоорондын шууд хамтын ажиллагааны талаар хоёр талт буюу олон талт хэлэлцээр байгуулах, эсхүл хүчин төгөлдөр хэлэлцээр байгаа бол тэдгээрт зохих журмын дагуу нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээ авна. Холбогдох Талуудын хооронд ийм хэлэлцээр, зохицуулалт байхгүй тохиолдолд Талууд Протоколд заасан гэмт хэрэгтэй холбоотой хууль сахиулах хамтын ажиллагаанд энэхүү Протоколыг үндэслэл болгож болно. Талууд хууль сахиулах байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг сайжруулахад олон улсын болон бүс нутгийн хэлэлцээр, зохицуулалтыг бүрэн ашиглана.
3. Талууд орчин үеийн технологи ашиглан үндэстэн дамжин үйлдсэн тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаанд хариу үйлдэл үзүүлэхэд бүхий л боломжоор хамтран ажиллах хүчин чармайлт гаргана.

**28 ДУГААР ЗҮЙЛ****ЗАХИРГААНЫ ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА**

Дотоодын хууль тогтоомж болон захиргааны тогтолцоонд нийцүүлэн Талууд бие биедээ хүсэлтээр нь эсхүл өөрийн санаачилгаар холбогдох мэдээлэл өгч, тамхи, тамхин бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн хууль бус худалдаатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөн байцаах, хянан шалгах ажиллагаанд гаалийн болон бусад холбогдох хуулийг үр дүнтэй ашиглах боломж олгоно. Мэдээллийг дамжуулж буй Тал өөрөөр мэдэгдсэнээс бусад тохиолдолд энэхүү мэдээллийг нууц, зөвхөн Талуудын хүрээнд ашиглах мэдээлэл гэж ойлгоно. Үүнд дараах мэдээлэл орж болно:

- (а) үр дүнтэй болох нь нотлогдсон гаалийн болон хууль хэрэгжүүлэх бусад арга;
- (б) тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн хууль бус худалдааны шинэ хандлага, арга, ажиллагаа;
- (в) тамхи, тамхин бүтээгдэхүүн эсхүл үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн хууль бус худалдаанд хамаарах бараа, тэдгээрийн дэлгэрэнгүй тодорхойлолт, сав баглаа, тээвэрлэлт болон хадгалалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- (г) 14 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэн эсхүл хам хэрэгт холбогдсон хувь хүн эсхүл хуулийн этгээд; болон
- (д) эрсдэлийн менежментийг хариуцсан эрх бүхий байгууллагад хяналт тавих болон хууль сахиулах бусад зорилгод нь дэмжлэг үзүүлэх бусад мэдээ.

**29 ДҮГЭЭР ЗҮЙЛ****ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА**

1. Талууд энэхүү Протоколын 14 дүгээр зүйлд заасан эрүүгийн гэмт хэргийг мөрдөн байцаах, хянан шалгах, шүүн таслах ажиллагааны явцад эрх зүйн туслалцааг хамгийн өргөн хүрээгээр харилцан үзүүлнэ.
2. Хүсэлт гаргасан Тал энэхүү Протоколын 15 дугаар зүйлд заасанчлан хариуцлага тооцох шаардлагатай гэж үзсэн хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн байцаах, хянан шалгах, шүүн таслах ажиллагаанд хүсэлтийг хүлээн авсан Тал холбогдох хууль, гэрээ, хэлэлцээр, зохицуулалтад нийцүүлэн боломжийн хэмжээнд эрх зүйн туслалцааг үзүүлнэ.
3. Энэхүү зүйлд заасан эрх зүйн харилцан туслалцааг дараах зорилгоор үзүүлнэ:
  - (а) хувь хүнээс нотлох баримт эсхүл мэдүүлэг авах;
  - (б) эрх зүйн баримт бичиг үйлдэх;
  - (в) нэгжлэг, хөрөнгө битүүмжлэх болон хураах ажиллагаа;
  - (г) эд зүйл, хэргийн газарт үзлэг хийх;
  - (д) мэдээлэл, эд мөрийн баримт, шинжээчийн үнэлгээ өгөх;
  - (е) төр, банк, санхүү, бизнесийн тайлан бүртгэл зэрэг холбогдох бичиг баримт болон тайлан бүртгэлийн эх хувь эсхүл баталгаажуулсан хуулбарыг өгөх;
  - (ж) нотолгоо бүрдүүлэх зорилгоор гэмт хэргээс олсон орлого, өмч хөрөнгө, арга хэрэгсэл эсхүл бусад эд зүйлийг тодорхойлох эсхүл хянан тогтоох;

- (з) хүсэлт гаргагч Талд хүмүүс сайн дураар очиж мэдүүлэг өгөх явдлыг хөхиүлэн дэмжих;
  - (и) хүсэлтийг хүлээн авах Талын дотоодын хууль тогтоомжид харшлаагүй бусад дэмжлэг туслалцаа.
4. Эрх зүйн харилцан туслалцааны асуудлыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн захирдаг буюу захирах аливаа хоёр талт эсхүл олон талт гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүрэгт энэхүү зүйл нөлөөлөхгүй.
  5. Талуудын хооронд эрх зүйн харилцан туслалцааны асуудлаар ямар нэгэн хэлэлцээр эсхүл засгийн газар хоорондын гэрээ байхгүй тохиолдолд энэхүү зүйлд нийцүүлэн тавьсан хүсэлтүүдэд 6-24 дүгээр заалтууд харилцан үйлчилнэ. Хэрэв Талуудын хооронд ийм төрлийн хэлэлцээр эсхүл засгийн газар хоорондын гэрээ байгаа бол Талууд энэхүү зүйлийн 6-24 дүгээр заалтуудыг ашиглахаар харилцан тохиролцооноос бусад тохиолдолд тэдгээр гэрээ, хэлэлцээр үйлчилнэ. Талууд хамтын ажиллагаандаа эдгээр заалтуудыг хэрэглэхийг хөхиүлэн дэмжинэ.
  6. Талууд эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг хүлээн авч, тэдгээрийг шийдвэрлэх эсхүл шийдвэрлүүлэхээр холбогдох эрх бүхий байгууллагуудад дамжуулах үүрэг, эрх мэдэл бүхий төв байгууллагыг томилно. Тухайн Талд эрх зүйн харилцан туслалцааны бие даасан тогтолцоотой тусгай бүс эсхүл нутаг дэвсгэр байгаа тохиолдолд тус бүс буюу нутаг дэвсгэр дээр ижил төстэй чиг үүргийг хэрэгжүүлэх тусдаа төв байгууллагыг томилж болно. Төв байгууллага нь хүлээж авсан хүсэлтийг зохих ёсоор шуурхай дамжуулах эсхүл шийдвэрлэх арга хэмжээ авна. Төв байгууллага нь хүсэлтийг шийдвэрлүүлэхээр эрх бүхий байгууллагад дамжуулсан тохиолдолд тус байгууллагаар хүсэлтийг зохих ёсоор шуурхай шийдвэрлүүлэх арга хэмжээ авна. Тал бүр энэхүү Протоколыг хүлээн зөвшөөрөх, нэгдэн орох, батлах болон соёрхон батлах үед дээрх зорилгоор тохоон томилсон төв байгууллагын талаар Конвенцын нарийн бичгийн даргын газрын тэргүүнд мэдэгдэнэ. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт болон үүнтэй холбоотой аливаа харилцаа холбоог Талуудын томилсон төв байгууллагууд хоорондоо дамжуулна. Энэхүү заалт нь эдгээр хүсэлт, харилцаа холбоог дипломат сувгаар эсхүл яаралтай тохиолдолд Талуудын харилцан зөвшилцсөний дагуу холбогдох олон улсын байгууллагуудаар дамжуулах Талуудын эрхийг хязгаарлахгүй.
  7. Хүсэлтийг бичгээр эсхүл бичмэл протокол үйлдэх боломжтой аливаа хэлбэрээр хүсэлтийг хүлээн авагч Талын хүлээн зөвшөөрсөн хэл дээр тухайн Талд хүсэлтийн жинхэнэ эхийг тогтоох боломж олгох нөхцөлтэйгөөр гаргана. Тал бүр энэхүү Протоколыг хүлээн зөвшөөрөх, нэгдэн орох, батлах болон соёрхон батлах үед хүлээн зөвшөөрөх нэг эсхүл хэд хэдэн хэлний талаар Конвенцын нарийн бичгийн даргын газрын тэргүүнд мэдэгдэнэ. Яаралтай тохиолдолд Талуудын харилцан зөвшилцсөний дагуу хүсэлтийг амаар тавьж, дараа нь бичгээр Баталгаажуулж болно.
  8. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтэд дараах зүйлийг заана:
    - (а) хүсэлт гаргагч эрх бүхий байгууллагын тухай мэдээ;
    - (б) тухайн хүсэлттэй холбоотой мөрдөн байцаах, хянан шалгах эсхүл шүүхийн үйл ажиллагааны гол агуулга болон мөн чанар, болон энэхүү мөрдөн байцаах, хянан шалгах эсхүл шүүхийн үйл ажиллагааг явуулж буй эрх бүхий байгууллагын нэр ба чиг үүрэг;
    - (в) шүүхийн бичиг баримтын үйлчилгээ авахаас бусад хүсэлтийн хувьд холбогдох нотолгооны товчоон;
    - (г) хүсч буй эрх зүйн туслалцаа болон хүсэлт гаргаж буй Талын зүгээс мөрдлөг болгохыг хүсч буй арга ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл;

- (д) боломжтой бол холбогдох хувь хүний тухай мэдээ, байршил, яс үндэс;
  - (е) ямар зорилгоор нотолгоо, мэдээллээр хангах эсхүл арга хэмжээ хэрэгжүүлэхийг хүсч буй тухай мэдээ; болон
  - (ж) эрүүгийн гэмт хэрэг, түүний ял шийтгэлтэй холбоотой дотоодын хууль тогтоомжийн заалт.
9. Хүсэлтийг хүлээн авагч Тал дотоодын хууль тогтоомжийн дагуу хүсэлтийг шийдвэрлэхэд шаардлагатай бусад нэмэлт мэдээлэл гаргуулах хүсэлт тавьж болно.
10. Хүсэлтийг хүлээн авагч Талын дотоодын хууль тогтоомжийн дагуу болон түүнд үл харшлах хүрээнд, мөн боломжтой бол хүсэлтэд заасан арга ажиллагаанд нийцүүлэн шийдвэрлэнэ.
11. Хүсэлт гаргагч Тал хүлээн авагч Талаас өгсөн мэдээллийг түүнээс урьдчилан авсан зөвшөөрөлгүйгээр хүсэлтэд зааснаас бусад мөрдөн байцаах, хянан шалгах, шүүн таслах ажиллагаанд ашиглах, дамжуулахыг хориглоно. Хүсэлт гаргагч Тал сэжигтэн этгээдийг цагаатгасан мэдээлэл эсхүл нотолгоог ил болгоход нь энэхүү заалт хориг болохгүй. Энэхүү мэдээллийг ил болгохоос өмнө хүсэлт гаргагч Тал хүлээн авагч Талд энэ тухай урьдчилан мэдэгдэж, хүлээн авагч Талын зүгээс шаардсан үед түүнтэй харилцан зөвлөлдөнө. Урьдчилан мэдэгдэх боломжгүй онцгой тохиолдолд хүсэлт гаргагч Тал мэдээлэл, нотолгоог ил болгосон тухайгаа хүлээн авагч Талд цаг алдалгүй мэдэгдэнэ.
12. Хүсэлт гаргагч Тал хүлээн авагч Талаас эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийг шийдвэрлэхэд шаардлагатайгаас бусад тохиолдолд ийнхүү хүсэлт гаргасан асуудал болон түүний агуулгыг нууцлахыг шаардаж болно. Хэрэв хүлээн авагч Тал нууцлалыг хадгалж чадахгүйд хүрвэл энэ тухайгаа хүсэлт гаргагч Талд даруй мэдэгдэнэ.
13. Тухайн Талын нутагт дэвсгэрт оршин сууж байгаа бөгөөд өөр Талын хууль зүйн эрх бүхий байгууллагад гэрчийн эсхүл шинжээчийн мэдүүлэг өгөх шаардлагатай хувь хүн хүсэлт гаргагч Талын нутаг дэвсгэрт биечлэн очих боломжгүй буюу хүсэлгүй байгаа тохиолдолд хүлээн авагч Тал нөгөө Талын хүсэлтийн дагуу видео конференц зохион байгуулж мэдүүлэг авах ажиллагааг боломжтой үед дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж болно. Энэхүү ажиллагааг хүсэлт гаргагч Талын хууль зүйн эрх бүхий байгууллага явуулж, хүлээн авагч Талын хууль зүйн эрх бүхий байгууллага байлцах талаар Талууд тохиролцож болно.
14. Дараах тохиолдолд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно:
- (а) хүсэлтийг энэхүү зүйлд нийцүүлэн гаргаагүй;
  - (б) хүсэлтийг хүлээн авагч Тал хүсэлтийг хэрэгжүүлэх нь түүний тусгаар тогтнол, аюулгүй байдал, нийтийн эмх замбараа эсхүл бусад амин чухал ашиг сонирхолд аюул учруулж болзошгүй гэж үзсэн;
  - (в) хүсэлтийг хүлээн авагч Талын эрх бүхий байгууллагуудад дотоодын хууль тогтоомжийн дагуу хүсэлтэд заасантай ижил төстэй хэргийг өөрийн харьяаллын дагуу мөрдөн байцаах, хянан шалгах, шүүн таслах ажиллагаа явуулахыг хориглосон;
  - (г) хүсэлтийг хүлээн авагч Талын хууль тогтоомжийн дагуу хүсэлтэд заасан гэмт хэрэгт дээд тал нь хоёр жилээс бага хугацаагаар хорих буюу бусад байдлаар эрх чөлөөг нь хязгаарлах ял ногдуулахаар бол, эсхүл хүлээн авагч Талын үзсэнээр эрх зүйн туслалцаа үзүүлэх зардал нь гэмт хэргийн хүнд хөнгөнтэй харьцуулахад хамаагүй их; эсхүл

- (д) эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт нь хүлээн авагч Талын хууль зүйн тогтолцоонд харшлахаар бол.
15. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс татгалзсан тохиолдол бүрт учир шалтгааныг тайлбарлах ёстой.
  16. Талууд банкны нууцад хамаарах гэсэн үндэслэлээр энэхүү зүйлийн хүрээнд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс татгалзахыг хориглоно.
  17. Талууд санхүүгийн холбогдолтой зөрчил гэсэн үндэслэлээр энэхүү зүйлийн хүрээнд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс татгалзаж болохгүй.
  18. Тухайн зөрчил хоёр Талын аль нэгэнд нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй гэж тооцогдохгүй тохиолдолд энэхүү зүйлийн хүрээнд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно. Гэсэн хэдий ч хүсэлтийг хүлээн авагч Тал өөрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу уг зөрчил гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй эсэхээс үл хамааран өөрийн зохистой гэж үзсэн хэмжээнд туслалцаа үзүүлж болно.
  19. Хүсэлт хүлээн авагч Тал эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг аль болох шуурхай, хүсэлт гаргагч Талын үндэслэл гарган санал болгосон хугацаанд боломжийн хирээр багтааж шийдвэрлэнэ. Хүсэлт хүлээн авагч Тал хүсэлтийг хэрэгжүүлэх чиглэлээр гарч буй ахиц дэвшлийн талаар хүсэлт гаргагч Талын зүй ёсны хүсэлтэд хариу өгнө. Хүсэлт гаргагч Тал цаашид туслалцаа шаардлагагүй болсон тохиолдолд энэ тухай хүлээн авагч Талд цаг алдалгүй мэдээлнэ.
  20. Хүсэлт нь мөрдөн байцаах, хянан шалгах, шүүн таслах бусад ажиллагаанд саад учруулж байна гэсэн үндэслэлээр хүлээн авагч Тал эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх асуудлыг хойшлуулж болно.
  21. Хүсэлт хүлээн авагч Тал 14 дүгээр заалтын дагуу хүсэлтийг шийдвэрлэхээс татгалзах эсхүл 20 дугаар заалтын дагуу хүсэлтийн шийдвэрлэлтийг хойшлуулахын өмнө өөрийн боломжтой гэж үзэж буй нөхцөлтэйгөөр туслалцаа үзүүлэхийг зөвшөөрөх эсэх талаар хүсэлт гаргагч Талтай зөвлөлдөнө. Хүсэлт гаргагч Тал санал болгож буй нөхцөлтэйгөөр туслалцааг авахыг хүлээн зөвшөөрвөл эдгээр нөхцөлийг дагаж мөрдөнө.
  22. Талууд өөрөөр харилцан тохиролцсоноос бусад тохиолдолд хүсэлтийг шийдвэрлэхэд шаардлагатай ердийн зардлыг хүсэлт гаргагч Тал хариуцна. Хэрэв хүсэлтийг шийдвэрлэхэд нэлээд их хэмжээний буюу онц их зардал гарахаар бол Талууд хүсэлтийг шийдвэрлэх болон зардлыг хариуцах нөхцөл дээрээ тохиролцоно.
  23. Эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийг хүлээн авсан Тал
    - (а) дотоодын хууль тогтоомжийн дагуу олон нийтэд нээлттэй Засгийн газрын бүртгэл, бичиг баримт эсхүл мэдээллийг хүсэлт гаргагч Талд гаргаж өгнө; мөн
    - (б) дотоодын хууль тогтоомжийн дагуу олон нийтэд хаалттай Засгийн газрын бүртгэл, бичиг баримт эсхүл мэдээллийг хүсэлт гаргагч Талд бүрэн эхээр нь, хэсэгчлэн эсхүл өөрийн шаардлагатай гэж үзсэн нөхцөлтэйгөөр гаргаж өгч болно.
  24. Талууд энэхүү зүйлийн хэрэгжилтийг хангах буюу эрчимжүүлэх зорилгоор хоёр буюу олон талт гэрээ, хэлэлцээрийг шаардлагын дагуу байгуулах боломжийг судална.

### 30 ДУГААР ЗҮЙЛ

#### СЭЖИГТЭН ЭТГЭЭДИЙГ ШИЛЖҮҮЛЭХ

1. Энэхүү зүйл нь Протоколын 14 дүгээр зүйлд заасны дагуу тогтоосон эрүүгийн гэмт хэрэгт дараах нөхцөлд хамаарна:
  - (а) сэжигтэн этгээд хүсэлтийг хүлээн авагч Талын нутаг дэвсгэр дээр нь байгаа;
  - (б) шилжүүлэн өгөх хүсэлтийн шалтгаан болсон эрүүгийн гэмт хэрэг нь хүсэлтийг гаргагч болон хүлээн авагч Талын аль алины дотоодын хууль тогтоомжийн дагуу шийтгэл ногдуулахаар бол; мөн
  - (в) тухайн гэмт хэрэгт дээд тал нь дөрөв буюу түүнээс их хугацаагаар хорих буюу бусад байдлаар эрх чөлөөг нь хязгаарлах ял, эсхүл илүү хүнд шийтгэл, эсхүл хоёр буюу олон талт хэлэлцээр буюу олон улсын бусад гэрээний дагуу Талуудын тохиролцсоноор үүнээс бага хугацааны шийтгэл ногдуулахаар бол.
2. Энэхүү зүйлийн хамаарах эрүүгийн гэмт хэрэг болгоныг Талуудын хооронд нэгэнт байгуулсан сэжигтэн этгээд шилжүүлэхтэй холбоотой аливаа гэрээнд хамруулан ойлгоно. Талууд цаашид хоорондоо байгуулах хэрэгтэн шилжүүлэхтэй холбоотой аливаа гэрээнд ийм гэмт хэргийг шилжүүлэн өгвөл зохих гэмт хэрэг гэж тусгах арга хэмжээ авна.
3. Хэрэв гэрээний үндсэн дээр сэжигтэн этгээдийг шилжүүлэн өгөх нөхцөл шаарддаг Тал түүнтэй ийм гэрээ байгуулаагүй Талаас шилжүүлэн өгөх тухай хүсэлт хүлээж авсан бол эдгээр хэргийн хувьд энэхүү Протоколыг сэжигтэн этгээдийг шилжүүлэн өгөх эрх зүйн үндэс хэмээн тооцож болно.
4. Сэжигтэн этгээдийг шилжүүлэн өгөхөд гэрээ байгуулсан байх нөхцөл шаарддаггүй Талуудын хувьд эдгээр гэмт хэргийг харилцан шилжүүлбэл зохих гэмт хэрэг гэж хүлээн зөвшөөрнө.
5. Сэжигтэн этгээдийг шилжүүлэх арга хэмжээг хүсэлт хүлээн авагч Талын дотоодын хууль тогтоомж эсхүл холбогдох гэрээ хэлэлцээрийн дагуу хэрэгжүүлэх ба үүнд сэжигтэн этгээдийг шилжүүлэн өгөхөд шаарддаг ялын доод хугацааны нөхцөл болон хүсэлтийг хүлээн авагч Тал сэжигтэн этгээдийг шилжүүлэн өгөхөөс татгалзах аливаа үндэслэлийг харгалзана.
6. Талууд дотоодын хууль тогтоомжийн хүрээнд энэхүү зүйлийн хамаарах эрүүгийн гэмт хэргийн сэжигтэн этгээдийг шилжүүлэх арга хэмжээг түргэвчилсэн байдлаар хэрэгжүүлэх, мөн гэмт хэргийн нотолгоонд тавих шаардлагыг хялбаршуулахыг эрмэлзэнэ.
7. Энэхүү зүйлийн хамаарах гэмт хэргийн сэжигтэн этгээд нутаг дэвсгэр дээр нь байгаа Тал уг этгээдийг өөрийн иргэн гэх цорын ганц үндэслэлээр шилжүүлэн өгөхөөс татгалзсан тохиолдолд сэжигтэн этгээдийг шилжүүлэн өгөх хүсэлтийг гаргасан Талын шаардлагын дагуу хэргийг ямар нэгэн саадгүйгээр эрх бүхий байгууллагуудад шилжүүлж хянан шийдвэрлүүлэх үүрэг хүлээнэ. Эдгээр эрх бүхий байгууллага нь ижил төстэй хэргийг дотоодын хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэх журмын дагуу тухай хэргийг хянан, шийдвэр гаргана. Холбогдох Талууд хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй болгох үүднээс ялангуяа горимын болон нотолгоо бүрдүүлэх тал дээр хамтран ажиллана.
8. Шилжүүлэн өгсөн сэжигтэнд оноосон ялыг шилжүүлэгч Талын нутаг дэвсгэр дээр эдлүүлэх нөхцөлийг хангасан тохиолдолд өөрийн иргэнийг нөгөө Талд шилжүүлэхээр дотоодын хууль тогтоомжид заасан бөгөөд Талууд энэхүү нөхцөл болон бусад зохистой гэж үзсэн нөхцөлүүдийг харилцан зөвшөөрсөн тохиолдолд ийм нөхцөлт

шилжүүлгийг энэхүү зүйлийн 7 дугаар заалтад заасан үүргийг биелүүлэхэд хангалттайд тооцно.

9. Ял эдлүүлэх зорилгоор гэмт этгээдийг шилжүүлэн өгөхийг хүссэн хүсэлтэд тус этгээд нь хүсэлт хүлээн авагч Талын иргэн гэсэн үндэслэлээр татгалзсан хариу өгсөн тохиолдолд хүлээн авагч Тал хүсэлт гаргасан Талын дотоодын хууль тогтоомжийн дагуу ногдуулсан энэхүү ялыг эдлүүлэх асуудлыг өөрийн дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ.
10. Энэхүү зүйлийн хамрах хүрээний аливаа эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон этгээдийг бүхий л шатанд хэргийг шударгаар хянан шийдвэрлүүлэх боломж, уг этгээд нутаг дэвсгэр нь байгаа Талын дотоодын хууль тогтоомжийн дагуу эдлэх бүх эрх, баталгаагаар хангана.
11. Сэжигтэн этгээдийг түүний хүйс, арьсны өнгө, шашин шүтлэг, яс үндэс, гарал үүсэл эсхүл улс төрийн үзэл бодлоос нь шалтгаалж мөрдөх эсхүл яллах зорилгоор шилжүүлэх хүсэлтийг гаргасан, эсхүл хүсэлтийг хэрэгжүүлэх нь дээрх үндэслэлээр тухайн хүнд хор хохирол учруулна гэж үзэх хангалттай үндэслэл хүсэлтийг хүлээн авагч Талд байгаа тохиолдолд энэхүү Протоколын аль ч заалт нь тус этгээдийг заавал шилжүүлэх үндэслэл болохгүй.
12. Талууд санхүүгийн холбогдолтой зөрчил гэсэн дан ганц үндэслэлээр энэхүү зүйлийн хүрээнд сэжигтэн этгээдийг шилжүүлэхээс татгалзаж болохгүй.
13. Сэжигтэн этгээдийг шилжүүлэхээс татгалзахын өмнө хүсэлтийг хүлээн авагч зохимжтой бол Тал хүсэлт гаргагч Талд өөрийн байр сууриа танилцуулах, тухайн этгээдийг буруутгах үндэслэл мэдээллээр хангах боломжийг бүрэн хэмжээгээр олгож зөвлөлдөнө.
14. Талууд сэжигтэн этгээдийг шилжүүлэх эсхүл энэхүү үйл ажиллагааны үр дүнг сайжруулах зорилгоор хоорондоо хоёр буюу олон талт гэрээ хэлэлцээр байгуулахыг эрмэлзэнэ. Талуудын хооронд энэ талаар нэгэнт байгуулсан засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээр байгаа тохиолдолд Талууд энэхүү зүйлийн 1-13 дугаар заалтыг баримтлахаар харилцан тохиролцсоноос бусад нөхцөлд тэрхүү засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийг мөрдлөг болгоно.

## 31 ДҮГЭЭР ЗҮЙЛ

### СЭЖИГТЭН ЭТГЭЭДИЙГ ШИЛЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

1. Хүсэлтийг хүлээн авсан Тал нөхцөл байдал яаралтай арга хэмжээ авахыг шаардсан гэж үзсэн бөгөөд хүсэлт гаргагч Талаас энэ тухай хүсэлт хүлээн авсан тохиолдолд нутаг дэвсгэр дээр нь байгаа сэжигтэн этгээдийг өөрийн нутаг дэвсгэр дээр байлгах талаар шаардлагатай арга хэмжээг дотоодын хууль тогтоомж, сэжигтэн этгээдийг шилжүүлэх тухай гэрээ хэлэлцээрийн хүрээнд авна.
2. Хүсэлтийг хүлээн авсан Тал 1 дүгээр заалтын дагуу авсан арга хэмжээний талаар дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн цаг алдалгүй хүсэлт гаргагч Талд мэдэгдэнэ.
3. 1 дүгээр заалтын дагуу арга хэмжээ авах шаардлагатай этгээд дараах эрх эдэлнэ:
  - (а) тухайн этгээдийн харьяалгадаг эсхүл тухайн этгээд харьяалалгүй бол байнга оршин суудаг улсын хамгийн ойрын албан ёсны төлөөлөгчид цаг алдалгүй мэдэгдэх; болон;
  - (б) тухайн улсын төлөөлөгчтэй уулзах.

## VI ХЭСЭГ: ТАЙЛАГНАХ

### 32 ДУГААР ЗҮЙЛ

#### МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ, ТАЙЛАГНАХ

1. Талууд Протоколын хэрэгжилтийн талаарх ээлжит тайланг Конвенцын нарийн бичгийн даргын газраар уламжлан Талуудын уулзалтад ирүүлнэ.
2. Тайлангийн маягт болон агуулгыг Талуудын уулзалтаас тогтооно. Тайлан нь ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын тайлангийн механизмын нэг хэсэг болно.
3. Энэхүү зүйлийн 1 дэх заалтад заасан ээлжит тайлангийн агуулгыг дараах зүйлсийг харгалзан тодорхойлно:
  - (а) энэхүү Протоколыг хэрэгжүүлэхээр хууль тогтоох, гүйцэтгэх, захиргааны болон бусад авч буй арга хэмжээний талаарх мэдээлэл;
  - (б) энэхүү Протоколыг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл, тэдгээр бэрхшээлийг даван туулахаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээлэл;
  - (в) тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгахтай холбоотой үйл ажиллагаанд зориулж өгсөн, хүлээн авсан эсхүл хүсэлт тавьсан санхүүгийн болон аргазүйн тусламжийн талаарх мэдээлэл; болон
  - (г) 20 дугаар зүйлд заасан мэдээлэл.

Холбогдох мэдээг Талуудын Бага Хурлын тайлангийн механизмаар дамжуулан нэгэнт цуглуулж хэвшсэн бол Талуудын уулзалт давхардуулан цуглуулах шаардлагагүй.
4. 33 ба 36 дугаар зүйлд заасны дагуу хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтийн улсууд энэ зүйлд заасан үүргээ биелүүлэхэд нь тэдний хүсэлтээр туслалцаа үзүүлэх арга хэмжээг Талуудын уулзалтаас авна.
5. Тэдгээр зүйл, заалтын хүрээнд тайлагнасан мэдээллийн нууцыг дотоодын хуулиар хамгаална. Талууд тайлагнасан эсхүл харилцан солилцсон мэдээллийн нууцыг харилцан тохиролцсон ёсоор хамгаална.



## **VII ХЭСЭГ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА САНХҮҮГИЙН НӨӨЦ**

### **33 ДУГААР ЗҮЙЛ**

#### **ТАЛУУДЫН УУЛЗАЛТ**

1. Энэхүү Протоколд оролцогч Талуудын уулзалтыг ийнхүү байгуулсан болно. Талуудын анхны уулзалтыг Конвенцын нарийн бичгийн даргын газраас энэхүү Протокол хүчин төгөлдөр болсноос хойш хуралдах Талуудын бага хурлын ээлжит хуралдаантай хамтруулан өмнө нь эсхүл дараа нь зарлан хуралдуулна.
2. Түүнээс хойш Талуудын уулзалтын ээлжит хуралдааныг Конвенцын нарийн бичгийн даргын газраас Талуудын бага хурлын ээлжит хуралдаантай хамтруулан өмнө нь эсхүл дараа нь зарлан хуралдуулна.
3. Талуудын уулзалтын онцгой хуралдааныг Талуудын уулзалтаас хэрэгтэй гэж үзсэн, эсхүл аль нэг Талаас бичгээр ирүүлсэн хүсэлтэд үндэслэн Конвенцын нарийн бичгийн даргын газраас хүсэлтийг Талуудад мэдэгдсэнээс хойш зургаан сарын дотор, Талуудын дор хаяж гуравны нэг нь дэмжсэн тохиолдолд зохион байгуулна.
4. Талуудын уулзалтаас өөрөөр шийдвэрлээгүй бол ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын Талуудын бага хурлын Үйл ажиллагааны болон санхүүгийн дүрэм Талуудын уулзалтад хүчин төгөлдөр үйлчилнэ.
5. Талуудын уулзалтаас энэхүү Протоколын хэрэгжилтийг тогтмол хянаж, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай шийдвэрийг гаргана.
6. Энэхүү Протоколыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөц болон бусад боломжит эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Талуудын оруулах сайн дурын хувь хандивын хэмжээний шатлал болон механизмыг Талуудын уулзалтаар шийдвэрлэнэ.
7. Талуудын уулзалтын ээлжит хуралдаан болгоноос дараагийн ээлжит хуралдаан хүртэлх хугацааны төсөв болон үйл ажиллагааны төлөвлөгөөг зөвшилцөн батлах ба энэ нь ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын төсөв болон үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс тусдаа байна.

### **34 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

#### **НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ГАЗАР**

1. Конвенцын нарийн бичгийн даргын газар энэхүү Протоколын нарийн бичгийн даргын газар байна.
2. Энэхүү Протоколын нарийн бичгийн даргын газрын хувьд Конвенцын нарийн бичгийн даргын газар нь дараах чиг үүрэгтэй байна:
  - (а) Талуудын уулзалт, мөн Талуудын уулзалтаас байгуулсан хамтарсан этгээд, ажлын хэсэг болон бусад этгээд, механизмын хуралдааныг зохион байгуулах, тэдэнд шаардлагатай үйлчилгээг үзүүлэх;
  - (б) энэхүү Протоколын дагуу хүлээн авсан тайлангийн талаар санал дүгнэлтийг хүлээн авах, дүн шинжилгээ хийх, дамжуулах, улмаар холбогдох Талууд болон Талуудын уулзалтад эргэн мэдээлэх, Талуудын хоорондын мэдээлэл солилцоог хангаж ажиллах;

- (в) Талууд, ялангуяа хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтэд байгаа Талуудад хүсэлтийнх нь дагуу баримт бүрдүүлэлт, харилцаа холбоо, мэдээлэл солилцооны талаар зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, тэдгээр Талуудад энэхүү Протоколоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, боломжит нөөцийг тодорхойлоход нь дэмжлэг үзүүлэх;
- (г) энэхүү Протоколын хүрээнд хийсэн үйл ажиллагааны тайланг Талуудын уулзалтын аргазүйн удирдлага дор бэлтгэж, Талуудын уулзалтад хүргүүлэх;
- (д) Талуудын уулзалтын аргазүйн удирдлага дор нөлөө бүхий олон улсын болон бүсийн засгийн газар хоорондын болон бусад байгууллагатай хэрэгцээт зохицуулалтыг хийх;
- (е) Талуудын уулзалтын удирдамжийн дагуу энэхүү Протоколын нарийн бичгийн даргын газрын чиг үүргийг үр дүнтэйгээр биелүүлэхэд шаардлагатай захиргааны болон гэрээт зохицуулалтыг хийх;
- (ж) засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагаас Талуудын уулзалтад ажиглагчаар оролцохыг хүссэн өргөдлийг хүлээн авч, эдгээр байгууллага нь тамхи үйлдвэрлэгчидтэй ямар нэг холбоогүй болохыг тогтоож, Талуудын уулзалтад танилцуулахаар бэлтгэх; болон
- (з) энэхүү Протоколд заасан нарийн бичгийн даргын газрын бусад ажил үүрэг болон Талуудын уулзалтаар тогтоосон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

### **35 ДУГААР ЗҮЙЛ**

#### **ТАЛУУДЫН УУЛЗАЛТ БОЛОН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН ХАРИЛЦАА**

Энэхүү Протоколын зорилтод хүрэхэд санхүү, техникийн хамтын ажиллагааг хангахын тулд Талуудын уулзалтаас нөлөө бүхий олон улсын болон бүсийн засгийн газар хоорондын байгууллагууд, санхүүгийн болон хөгжлийн хүрээлэнд хамтын ажиллагааны хүсэлт гаргаж болно.

### **36 ДУГААР ЗҮЙЛ**

#### **САНХҮҮГИЙН НӨӨЦ**

1. Талууд энэхүү Протоколын зорилтод хүрэхэд санхүүжилт чухал үүрэгтэй болохыг, мөн ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын зорилтыг хэрэгжүүлэхэд тус конвенцын 26 дугаар зүйл чухал болохыг хүлээн зөвшөөрнө.
2. Тал бүр энэхүү Протоколын зорилтод хүрэхийн тулд төлөвлөсөн үндэсний үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн дэмжлэгийг үндэсний төлөвлөгөө, тэргүүлэх чиглэл болон хөтөлбөрүүдэд нийцүүлэн үзүүлнэ.
3. Талууд энэхүү Протоколын зорилтод хүрэхийн тулд хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтэд байгаа Талуудын чадавхийг бэхжүүлэхийн тулд хоёр талт, бүсийн, дэд бүсийн болон бусад олон талт сувгуудыг боломжтой байдлаар ашиглахыг хөхиүлэн дэмжинэ.
4. 18 дугаар зүйлд хор хохирол учруулахгүйгээр Талууд энэхүү Протоколд заасан зорилтод хүрэхийн тулд тамхи, тамхин бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлд ашигладаг тоног төхөөрөмжийн хууль бус худалдаанаас олж авсан аливаа хураагдсан орлогыг хэрэглэхийг хөхиүлэн дэмжинэ.

5. Холбогдох бүс нутгийн болон олон улсын засгийн газар хоорондын байгууллагууд болон хөгжлийн хүрээлэнгүүдэд төлөөлөл бүхий Талууд тэдгээр байгууллагуудыг хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтэд байгаа Талуудад энэхүү Протоколоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь санхүүгийн тусламж үзүүлэх, ингэхдээ тэдний тухайн байгууллагуудад оролцох эрхийг нь хязгаарлахгүй байхыг уриална.
6. Талууд дараах зүйлийг зөвшөөрнө:
  - (а) Талуудад энэхүү Протоколоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь туслахын тулд энэхүү Протоколын зорилттой холбоотой үйл ажиллагаанд зориулагдах боломжтой бүх нөөцийг дайчилж, бүх Тал, ялангуяа хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтэд байгаа Талуудын үр ашгийн төлөө ашиглахыг; болон
  - (б) Конвенцын нарийн бичгийн даргын газар хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтэд байгаа Талуудад тэдний хүсэлтээр энэхүү Протоколд заасан үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийн талаар зөвлөхийг.
7. ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын 5.3 дугаар зүйлд заасны дагуу энэхүү Протоколын зорилтыг хэрэгжүүлэх талаар Талууд хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардагдах аливаа зардлыг тамхи үйлдвэрлэгчээс гаргуулахыг шаардаж болно.
8. Талууд дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн тамхин бүтээгдэхүүнд татвар болон бусад төлбөр ногдуулах болон бусад аргаар энэхүү Протоколын хэрэгжилтийг бие даан санхүүжүүлэхийг эрмэлзэнэ.

## **VIII ХЭСЭГ: МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

### **37 ДУГААР ЗҮЙЛ МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

Талуудын дунд энэхүү Протоколыг тайлбарлах, эсхүл хэрэглэхтэй холбоотой маргаан гарвал ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын 27 дугаар зүйлийг удирдлага болгон шийдвэрлэнэ.

## **IX ХЭСЭГ: ПРОТОКОЛЫН БОЛОВСРУУЛАЛТ**

### **38 ДУГААР ЗҮЙЛ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ**

1. Аль ч Тал Протоколд нэмэлт өөрчлөлт санал болгож болно.
2. Энэхүү Протоколд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Талуудын уулзалтаар хэлэлцэж батална. Протоколд санал болгож буй аливаа нэмэлт өөрчлөлтийн бичвэрийг Конвенцын нарийн бичгийн даргын газраар уламжлан уулзалтаар батлуулахаар санал оруулахаас наад тал нь зургаан сарын өмнө Талуудад мэдэгдэнэ. Санал болгож буй нэмэлт өөрчлөлтийг Конвенцын нарийн бичгийн даргын газар Протоколд гарын үсэг зурсан Талуудад мэдээлж, Эх хадгалагчид мэдэгдэнэ.
3. Талууд энэхүү Протоколд санал болгож буй аливаа нэмэлт өөрчлөлт бүрийн талаар зөвшилцөлд хүрэхийн тулд бүхий л хүчин чармайлтыг гаргана. Зөвшилцөлд хүрэх гэсэн бүхий л хүчин чармайлт барагдаж, тохиролцоонд хүрээгүй бол нэмэлт өөрчлөлтийг Талуудын уулзалтад оролцож саналаа өгсөн Талуудын дөрөвний гурвын саналаар батална. Энэ зүйлд гарч буй «уулзалтад оролцож саналаа өгсөн Тал» гэж зөвшөөрөх эсхүл татгалзах санал өгсөн Талыг ойлгоно. Батлагдсан аливаа нэмэлт өөрчлөлтийг Конвенцын нарийн бичгийн даргын газар Эх хадгалагчид хүргүүлж, Эх хадгалагч нь бүх Талд хүлээн зөвшөөрүүлэхээр дамжуулна.
4. Нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн баримт бичгийг Эх хадгалагч хадгална. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу батлагдсан нэмэлт өөрчлөлт нь Талуудын гуравны хоёр нь хүлээн зөвшөөрсөн тэрхүү баримт бичгийг Эх хадгалагч хүлээн авснаас хойш ер дэх хоног дээр түүнийг хүлээн зөвшөөрсөн Талуудын хувьд хүчин төгөлдөр болно.
5. Нэмэлт өөрчлөлт нь бусад Талын хувьд тухайн нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн баримт бичгийг тухайн Тал Эх хадгалагчид хадгалуулснаас хойш ер дэх хоног дээр хүчин төгөлдөр болно.

### **39 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

#### **ЭНЭХҮҮ ПРОТОКОЛЫН ХАВСРАЛТЫГ БАТЛАХ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

1. Аль ч Тал энэхүү Протоколд хавсралт нэмэх, хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулахыг санал болгож болно.
2. Хавсралт нь процедур, шинжлэх ухаан, техник, захиргаатай холбоотой асуудлаарх жагсаалт, маягт болон бусад бичиглэл материалаар хязгаарлагдана.
3. Энэхүү Протоколын хавсралт, нэмэлт өөрчлөлтийг 38 дугаар зүйлд заасны дагуу санал болгож, баталж, хүчин төгөлдөр болгоно.

## **Х ХЭСЭГ: БУСАД**

### **40 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

#### **ТАЙЛБАР**

Энэхүү Протоколд аливаа тайлбар хийхгүй.

### **41 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

#### **ЦУЦЛАХ**

1. Энэхүү Протокол тухайн Талын хувьд хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хоёр жил өнгөрсний дараа тухайн Тал Эх хадгалагчид бичгээр мэдэгдэл өгч Протоколыг цуцалж болно.
2. Ийнхүү цуцалсан нь Эх хадгалагч цуцлах тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш нэг жилийн дараа, эсхүл цуцлах тухай мэдэгдэлд заасан дараагийн өдрөөс хүчин төгөлдөр болно.
3. ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцыг цуцалж байгаа Талыг энэхүү Протоколыг мөн цуцалж байгаад тооцох бөгөөд Тамхины Хяналтын Суурь Конвенцыг цуцалсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

### **42 ДУГААР ЗҮЙЛ**

#### **САНАЛ ӨГӨХ ЭРХ**

1. Энэхүү Протоколын Тал бүр энэ зүйлийн 2 дахь заалтад зааснаас бусад тохиолдолд нэг саналын эрхтэй байна.
2. Бүс нутгийн эдийн засгийн интеграцийн байгууллагууд тэдгээрийн бүрэн эрхийн хүрээнд Протоколд оролцогч өөрийн гишүүн улсын тоотой тэнцүү тооны саналын эрх эдэлнэ. Аль нэг гишүүн орон нь энэхүү эрхээ бие даан эдэлбэл байгууллага нь тэрхүү улсын саналын эрхийг эдлэхгүй.

### **43 ДУГААР ЗҮЙЛ**

#### **ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ**

Протокол нь ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын Талуудын хувьд Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Женев дахь Төв байранд 2013 оны 1 дүгээр сарын 10-11-ний өдрүүдэд, түүнээс хойш 2014 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр хүртэл Нью-Йорк дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Төв байранд гарын үсэг зурахад нээлттэй байна.

### **44 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

#### **СОЁРХОН БАТЛАХ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, БАТЛАХ БОЛОН НЭГДЭН ОРОХ**

1. Энэхүү Протокол нь ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын Тал болох улсуудын хувьд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах болон нэгдэн орох, мөн бүсийн эдийн засгийн интеграцийн байгууллагуудын хувьд нэгдэн ороход нь нээлттэй

байна. Протокол гарын үсэг зурагдахаар хаагдсан өдрийн дараагийн өдрөөс эхлэн нэгдэн ороход нээлттэй байна. Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах болон нэгдэн орох тухай баримт бичгийг Эх хадгалагчид хадгалуулна.

2. Гишүүн улсууд нь Протоколын тал болоогүй бүсийн эдийн засгийн интеграцийн байгууллага энэхүү Протоколын Тал болсон нөхцөлд Протоколын дагуу хүлээсэн бүх үүргийг биелүүлнэ. Ийм байгууллагын хувьд, нэг буюу хэд хэдэн гишүүн улс нь энэ Протоколын Тал болсон тохиолдолд байгууллага болон гишүүн улс нь энэхүү Протоколын дагуу хүлээсэн үүргийн гүйцэтгэлээ тус тусдаа хариуцах эсэхээ шийднэ. Ийм тохиолдолд байгууллага болон гишүүн улс энэ Протоколын дагуу давхар эрх эдлэхгүй.
3. Бүсийн эдийн засгийн интеграцийн байгууллага нь тэрхүү соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн буюу баталсан тухай баримт бичигт энэхүү Протоколын хүрээнд зохицуулагдаж буй асуудлуудын хувьд өөрийн эдлэх эрх хэмжээний талаар зарлан мэдэгдэнэ. Тэдгээр байгууллагууд өөрийн эрх хэмжээнд орсон аливаа өөрчлөлтийн талаар Эх хадгалагчид, Эх хадгалагч нь Талуудад мэдээлнэ.

## **45 ДУГААР ЗҮЙЛ**

### **ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ**

1. Энэхүү Протокол нь түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан буюу нэгдэн орсон тухай дөч дэх баримт бичгийг Эх хадгалагчид хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш ер дэх өдөр хүчин төгөлдөр болно.
2. Энэхүү Протоколыг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, баталж буюу нэгдэн орж буй ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенцын Тал бүрийн хувьд энэхүү Протокол нь соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан буюу нэгдэн орсон баримт бичгээ Эх хадгалагчид хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш ер дэх өдөр буюу энэхүү зүйлийн 1 дэх заалтын дагуу энэхүү Протокол хүчин төгөлдөр болсон өдрийн аль хожуу тохиосонд хүчин төгөлдөр болно.
3. Энэ зүйлийн зорилтыг хангах үүднээс бүсийн эдийн засгийн интеграцийн байгууллагын хадгалуулсан аливаа баримт бичиг тэрхүү байгууллагын гишүүн улсуудын хадгалуулсан баримт бичгийн нэмэлт хэмээн тоологдохгүй.

## **46 ДУГААР ЗҮЙЛ**

### **ЭХ ХАДГАЛАГЧ**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга нь энэхүү Протоколын эх хадгалагч мөн болно.

## **47 ДУГААР ЗҮЙЛ**

### **ЖИНХЭНЭ БИЧВЭР**

Англи, араб, испани, орос, франц ба хятад хэлээр үйлдсэн бичвэрүүд нь адил хүчинтэй энэхүү Протоколын жинхэнэ эхийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.